| 116   | Улаанбаатар-Дархан чиглэлийн 204,6 км авто замын шинэчлэлийн төсөл                       | Бэлтгэл ажил.<br>Зураг төслийг бэлэн болгож, АХБ-аас зөвшөөрөл авсан. | Зураг төслийг бэлэн болгож, АХБ-аас зөвшөөрөл авсан. | Төслийн ажлын явц 30 хувь.<br>ТЗЗУС, ТЗСТ хийнэ.  | Төслийн ажлын явц 75 хувь.<br>Авто зам, гүүрийн өргөтгөл шинэчлэлийн ажлыг гүйцэтгэнэ.                                | ЗТХЯ  |
| 117   | Багануур-Мөнгөнорьт чиглэлийн хатуу хучилттай 60 км авто зам                             | -   | -  | Төслийн ажлын явц 10 хувь.<br>Барилгын ажлыг эхлүүлнэ.  | Төслийн ажлын явц 100 хувь.<br>Барилгын ажлыг дуусган, ашиглагтаанд өгнө.   | ЗТХЯ  |
| 118   | Далаанжаргалан-Бор-Өндөр чиглэлийн хатуу хучилттай 50 км авто зам                        | -   | -  | Төслийн ажлын явц 10 хувь.<br>Барилгын ажлыг эхлүүлнэ.  | Төслийн ажлын явц 100 хувь.<br>Барилгын ажлыг дуусган, ашиглагтаанд өгнө.   | ЗТХЯ  |
| 119   | Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, 63 км авто замын ажил | -   | -  | Төслийн ажлын явц 10 хувь.<br>Барилгын ажлыг эхлүүлнэ.  | Төслийн ажлын явц 100 хувь.<br>Барилгын ажлыг дуусган, ашиглагтаанд өгнө.   | ЗТХЯ  |

|   |  | Сангийн сайд  |   |   |       |
|---|--|---|---|---|-------|
| 120                                     | Улсын чөлөөтэй авто зам, гүүрний засвар, эрчимтэд /улсын хэмжээнд/   | -   | Төслийн ажлын явц 100 хувь. Зам харуулагч төрийн өмчит 20, хувийн хэвшлийн 8, нийт 28 компанигай гэжээ байгуулан ажиллаж байна.   | -   | ЗТХЯ  |
| 121                                     | Гаалийн ерөнхий газар, газар хороорын шуурхай удирдлагын төв, хяналт, шалгалтын тоног төхөөрөмж                    | -   | Төслийн ажлын явц 84 хувь. Гаалийн хяналтын тоног төхөөрөмжийг худалдан авч, суурилуулана.  | Төслийн ажлын явц 100 хувь. Шуурхай удирдлагын төвийн барилгын ажлыг дуусган, хяналтын тоног төхөөрөмжүүдийг ашиглаж эхэлнэ.                              | СЯ    |
| 122                                     | Гаалийн шинэчлэл - Гаалийн хороо, гаалийн төв болон газар хороорын лабораторийн барилга /улсын хэмжээнд 6 байршил/ | -   | Төслийн ажлын явц 99 хувь. Гаалийн лабораторийн барилга, байгууламжийг барих ажлыг эхлүүлнэ.  | Төслийн ажлын явц 100 хувь. Гаалийн лабораторийн барилга, байгууламжийг барих ажлыг дууссан байна.  | СЯ    |
| <b>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд</b> |  |   |   |   |       |
| 123                                     | Газрын тос дамжуулах хоолой барих төсөл  | <b>Бэлтгэл ажил.</b> Үйлдвэрийн болон түүхий тос дамжуулах хоолой дамжин өнгөрөх газрыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу Улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг шийдвэрлүүлсэн.                    | Төслийн ажлын явц 20 хувь. Газрын тос дамжуулах хоолой барих төслийн ТЭЗҮ боловсруула.  | Төслийн ажлын явц 40 хувь. Газрын тос дамжуулах хоолой барих төслийн газар шорооны ажлыг эхлүүлнэ.  | УУХҮЯ |
| 124                                     | Үндэсний алт цэвэршүүлэх үйлдвэрийн төсөл  | <b>Бэлтгэл ажил.</b> Алт цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврын төслийг боловсруулсан.   | Төслийн ажлын явц 20 хувь. Үйлдвэрийн ТЭЗҮ-ийг боловсруулан, технологийн сонголтлыг хийж, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэнэ.   | Төслийн ажлын явц 100 хувь. Барилга, тоног төхөөрөмж урсгалтын ажлыг гүйцэтгэнэ.  | УУХҮЯ |
| 125                                     | Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн төсөл   | <b>Бэлтгэл ажил.</b> Газрын асуудлыг шийдвэрлэсэн. Байгалийн хийн үйлдвэрлэл шаардлагатай олон улсын ISO, ГОСТ стандартуудыг боловсруулсан.   | Төслийн ажлын явц 20 хувь. Үндсэн зураг төслийн дагуу төслийн талбайг бэлтгэх, мэргэжлийн боловсон хүчинд суурь мэдлэг олгоно.  | Төслийн ажлын явц 40 хувь. Үйлдвэрийн барилгыг барьж эхлүүлнэ.  | УУХҮЯ |
| 126                                     | Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төсөл   | <b>Бэлтгэл ажил.</b> Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн урь-хичлэсэн ТЭЗҮ-ийг хийж, хүлээлгэн өгсөн. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэн, тайланг хүлээн авсан. | Төслийн ажлын явц 20 хувь. Хөрөнгө оруулагчийг сонгон, гэрээ байгуулж, үндсэн зураг төслийн дагуу төслийн талбайг бэлтгэх, мэргэжлийн боловсон хүчинд суурь мэдлэг олгох сургалт явуулна. | Төслийн ажлын явц 60 хувь. Үйлдвэрийн барилгыг барьж ажлыг гүйцэтгэнэ.  | УУХҮЯ |
| <b>Хууль зүй, дотоод хэргийн сайд</b>   |  |   |   |   |       |
| 127                                     | Цагдаагийн байгууллагын хэт болно долгионы радио холбооны шинэчлэл хийх  | -   | Төслийн ажлын явц 30 хувь. Улаанбаатар цагдаагийн хүрээний байгууллагуудыг тоон технологийн радио стандартар бүрэн хангана.   | Төслийн ажлын явц 60 хувь. Орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдийг тоон технологийн радио стандартар бүрэн хангана. /Гөвийн болон зүүн бүс/ өмнөд бүс/ | ХЗДХЯ |



|     |  |   |  |  |         |
|-----|--|---|--|--|---------|
| 128 | Цагдаагийн байгууллагын авто парк шинэчлэх   | - | <b>Төслийн ажлын явц 50 хувь.</b><br>Улаанбаатар хотын газар, хэлтсүүдийн парк шинэчлэл хийж, шуурхай албаны бэлэн байдлыг дээшлүүлнэ.   | <b>Төслийн ажлын явц 100 хувь.</b><br>Орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдийн парк шинэчлэл хийж, шуурхай албаны бэлэн байдлыг дээшлүүлнэ.  | Хэдхя   |
| 129 | Хил хамгаалах байгууллагын авто парк шинэчлэл  | - | -  | <b>Төслийн ажлын явц 60 хувь.</b><br>Хилийн отряд, асгавнын шуурхай ажиллагааны зориулалтаар ашиглах судлын автомашинаар хангах - 100 нэгж, Хүрээхэд хүндэтгэлтэй хилийн хэсэгт тээвэр хийх автомашинаар хангах - 9 нэгж, Тусгай бүлгийн шуурхай дуудлагын машин - 2 нэгж, Хилийн манааны уналгаар хангах цасны чарга/ - 10 нэгж | Хэдхя   |
| 130 | "Нэг иргэн-нэг бүртгэл" үндэсний хөнгөлбөр   | - | <b>Төслийн ажлын явц 50 хувь.</b><br>Бүртгэлийн байгууллагын системийн хэмжээнд техник, тоног төхөөрөмжийн 50 %-ийг болон 3 програм хангамжийг шинэчилсэн байна. Архивын эх нотлох баримтыг бүрэн шахимжуулах ажлыг 100 % хийсэн байна. Дэд бүтцийн зураг, төслийг боловсруулна. | <b>Төслийн ажлын явц 100 хувь.</b><br>Дэд бүтцийг шинэчлэн зохион байгуулна. Бүртгэлийн мэдээллийн сан, програм хангамжид олон улсын технологийн чиг хандлагад нийцсэн мэдээллийн сангийн удирдлагын шинэ технологи нэвтрүүлсэн байна.   | Хэдхя   |
| 131 | Архивын ерөнхий газрын шогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл | - | <b>Төслийн ажлын явц 15 хувь.</b><br>Төслийн үр дүнг шалгуур үзүүлэлтийн зорилгот тувшинд хүргэсэн байна.  | <b>Төслийн ажлын явц 65 хувь.</b><br>Төслийн үр дүнг шалгуур үзүүлэлтийн зорилгот тувшинд хүргэсэн байна.  | Хэдхя   |
| 132 | Биоклимат үйлдвэрийн өргөтгөл  | - | <b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</b><br><b>Төслийн ажлын явц 5 хувь.</b>   | <b>Төслийн ажлын явц 30 хувь.</b>  | ХХААХУЯ |
| 133 | Эрхтэн шилжүүлэн суулгах-Мас астын гэв байгуулах төсөл                                     | - | <b>Эрүүл мэндийн сайд</b><br><b>Төслийн ажлын явц 30 хувь.</b><br>Барилгын ажил эхэлсэн байна.   | <b>Төслийн ажлын явц 100 хувь.</b><br>Барилгыг урьдчилж комисст хүтээлгэн өгнө.  | ЭМЯ     |
| 134 | Эрүүл мэндийн салбарын хөгжил хөнгөлбөр-6  | - | <b>Төслийн ажлын явц 5 хувь.</b><br>Төслийн үр дүнг шалгуур үзүүлэлтийн зорилгот тувшинд хүргэсэн байна.   | <b>Төслийн ажлын явц 15 хувь.</b><br>Төслийн үр дүнг шалгуур үзүүлэлтийн зорилгот тувшинд хүргэсэн байна.  | ЭМЯ     |

|                          |   |   |   |  |   |         |
|--------------------------|---|---|---|--|---|---------|
| 135                      | Зурх судвсны үндэсний төв байгуулах   | -   | - | <b>Төслийн ажлын явц 40 хувь.</b><br>Шардлагагай хөрөнгө оруулалтыг олж, төслийн барилгын ажлыг эхлүүлнэ.              | <b>Төслийн ажлын явц 70 хувь.</b><br>Барилгын ажлыг гүйцэтгэнэ. Олон улсын жишигт нийцсэн өндөр стандартаг, аюулгүй байдлыг бүрэн хангасан тоног төхөөрөмж, тавилга эд хойшлыг суурилуулах ажил явагдана. | ЭМЯ     |
| 136                      | Азлын тэргүүлэх хавдар судлалын төв байгуулах   | -   | - | <b>Төслийн ажлын явц 40 хувь.</b><br>Шардлагагай хөрөнгө оруулалтыг олж, төслийн барилгын ажлыг эхлүүлнэ.              | <b>Төслийн ажлын явц 70 хувь.</b><br>Барилгын ажлыг гүйцэтгэнэ. Олон улсын жишигт нийцсэн өндөр стандартаг, аюулгүй байдлыг бүрэн хангасан тоног төхөөрөмж, тавилга эд хойшлыг суурилуулах ажил явагдана. | ЭМЯ     |
| <b>Эрчим хүчний сайд</b> |   |   |   |  |   |         |
| 137                      | Тохируулгын горимд ажиллах том чадлын цэнэг хураагуур барих төсөл   | -   | - | <b>Төслийн ажлын явц 20 хувь.</b><br>Төслийн ТЗЗГ боловсруулна. Барилга угсралтын ажил эхлүүлнэ.                       | <b>Төслийн ажлын явц 100 хувь.</b><br>Тохируулгын горимд ажиллах том чадлын цэнэг хураагуур барьж, ашиглалтанд оруулна.   | ЭХЯ     |
| 138                      | Улаанбаатар хотын Дулааны 2 дугаар цахилгаан станцон хүчин чадлыг 300 МВт-аар өргөтгөх                        | -   | - | <b>Бэлтгэл ажил</b><br>Төслийг эхлүүлэх бэлтгэл хангагдана.  | <b>Төслийн ажлын явц 10 хувь.</b><br>Гэрээ хэлэлцээрийг эхлүүлнэ. Төног төхөөрөмжийн захиалгыг хийж эхлүүлнэ.   | ЭХЯ     |
| 139                      | Улаанбаатар хотын цахилгаан станцон өндөр даралтын хэсгийн хүчин чадлыг 75 МВт-аар өргөтгөх                   | <b>Бэлтгэл ажил.</b><br>Санхүүжилтийг шийдвэрлэхээр ажиллаж байна.  | - | <b>Төслийн ажлын явц 60 хувь.</b><br>Санхүүжилтийг шийдвэрлэнэ. ТЗЗУ, БОНУ хийгдэнэ. барилга угсралтын ажлыг эхлүүлнэ. | <b>Төслийн ажлын явц 100 хувь.</b><br>Ашиглалтанд орно.   | ЭХЯ     |
| 140                      | Улаанбаатар хотын Амгалан дулааны станцыг 50 МВт-ын дулаан, цахилгаан хослон үйлдвэрлэх станц болгон өргөтгөх | <b>Бэлтгэл ажил.</b><br>Санхүүжилтийг шийдвэрлэхээр ажиллаж байна.  | - | <b>Төслийн ажлын явц 35 хувь.</b><br>Санхүүжилтийг шийдвэрлэнэ. ТЗЗУ, БОНУ хийгдсэн байна.                             | <b>Төслийн ажлын явц 100 хувь.</b><br>Ашиглалтанд орно.   | ЭХЯ     |
| 141                      | Нийслэлийн агаар, орчны бохирдлыг бууруулах эрчим хүчний дэмжүүлэх, түгээх шугам сулгах                       | <b>Төслийн ажлын явц 95 хувь.</b><br>СХД, БГД, ЧД, СБД 4 дүүргийн 20602 айл өрхийг 4 кВт чадлын цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэх 26 багц ажил хийгдэж дууссан. | - | <b>Төслийн ажлын явц 100 хувь.</b><br>Санхүүжилтийг бүрэн шийдвэрлүүлж, төслийг бүрэн дуусгана.                        | <b>Төслийн ажлын явц 100 хувь.</b><br>Гүйцэтгэчийг сонгон, барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ.  | СЯ, ЭХЯ |



|   |  |   |  |   |  |              |
|---|--|---|--|---|--|--------------|
| 142   | “Чойр” дэд станцэн өргөтгөл шинэчлэлт /Концессын эргэн төлөлт/   | Төслийн ажлын явц 100 хувь. Барих-шилжүүлэх концессын гэрээгээр ажиг хийгдэж дууссан. Улсын төсвөөс концессын эргэн төлөлт хийгдэж байна. | Эргэн төлөлт 40 хувь. Төсвөөс концессын эргэн төлөлт хийгдэнэ.   | Эргэн төлөлт 95 хувь. Төсвөөс концессын эргэн төлөлт хийгдэнэ.  | Эргэн төлөлт 100 хувь. Төсвөөс концессын эргэн төлөлт хийгдэнэ.            | СЯ, УХГ, ЭХЯ |
| 143   | Оюутолгой-Цагаанцавлага шилдэглэлийн 220 кВ-ын човар хэлхээг ЦДАШ дэд станц /Концессын эргэн төлөлт/   | Төслийн ажлын явц 100 хувь. Барих-шилжүүлэх концессын гэрээгээр ажиг хийгдэж дууссан. Улсын төсвөөс концессын эргэн төлөлт хийгдэж байна. | Эргэн төлөлт 10 хувь. Төсвөөс концессын эргэн төлөлт хийгдэнэ.   | Эргэн төлөлт 95 хувь. Төсвөөс концессын эргэн төлөлт хийгдэнэ.  | Эргэн төлөлт 100 хувь. Төсвөөс концессын эргэн төлөлт хийгдэнэ.            | СЯ, УХГ, ЭХЯ |
| <b>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч</b> |  |   |  |   |  |              |
| 144   | Багахангай хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк   | -   | Төслийн ажлын явц 10 хувь. Паркийн хөдөлгөөнийг эрхэмийг төлөвлөгөө боловсруулж багтуулна.   | Төслийн ажлын явц 20 хувь. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийгдэнэ. Дэд бүтцийн зураг төсөл боловсруулна.   | Төслийн ажлын явц 30 хувь. Дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. | НЭДТГ        |
| 145   | Ашиглалтын шаардлага хангахуй байгаа нийтийн зориулалттай орон сууцны 58 барилгыг буулган, шинээр барих төсөл /нийслэлийн хэмжээнд 6 дүүрэг/ | -   | Төслийн ажлын явц 30 хувь. Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулна. Түлхүүр гардуулах нөхцөлөөр төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ байгуулна. | Төслийн ажлын явц 80 хувь. Барилга буулгалт болон угсралтын ажилд шаардлагатай зөвшөөрлийг бүрдүүлэн, барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ. Түрээсийн орон сууц хөтөлбөрт иргэдийг хамруулна. | Төслийн ажлын явц 100 хувь. Барилгын улсын комисст хүлээлгэн өгнө.         | НЭДТГ        |
| 146   | Газар хөдөлгөөнийг нормын шаардлага хангахуй байгаа нийслэлийн төрийн өмчийн сургуулиудын барилгыг буулгаж, шинэчлэн барих                   | -   | Төслийн ажлын явц 30 хувь. Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулна. Түлхүүр гардуулах нөхцөлөөр төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ байгуулна. | Төслийн ажлын явц 80 хувь. Барилга буулгалт болон угсралтын ажилд шаардлагатай зөвшөөрлийг бүрдүүлэн, барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ. Түрээсийн орон сууц хөтөлбөрт иргэдийг хамруулна. | Төслийн ажлын явц 100 хувь. Барилгын улсын комисст хүлээлгэн өгнө.         | НЭДТГ        |
| 147   | Газар хөдөлгөөнийг нормын шаардлага хангахуй байгаа нийслэлийн төрийн өмчийн цэцэрлэгүүдийн барилгыг буулгаж, шинэчлэн барих                 | -   | Төслийн ажлын явц 30 хувь. Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулна. Түлхүүр гардуулах нөхцөлөөр төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ байгуулна. | Төслийн ажлын явц 80 хувь. Барилга буулгалт болон угсралтын ажилд шаардлагатай зөвшөөрлийг бүрдүүлэн, барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ. Түрээсийн орон сууц хөтөлбөрт иргэдийг хамруулна. | Төслийн ажлын явц 100 хувь. Барилгын улсын комисст хүлээлгэн өгнө.         | НЭДТГ        |
| 148   | Налайхан дугааны станцэн өргөтгөх  | -   | Бэлтгэл ажил. Зураг, төсөл боловсруулна.   | Төслийн ажлын явц 20 хувь. Барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.  | Төслийн ажлын явц 40 хувь. Барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ.             | НЭДТГ        |
| 149   | Нийтийн зорилгч тээвэрт парк шинэчлэлт хийх  | -   | Төслийн ажлын явц 100 хувь. 250 тээврийн хэрэгсэлээр парк шинэчлэлт хийж, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч ах ахуйн нэгж байгууллагуудад хуваарилна.                         | -   | -  | НЭДТГ        |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 7 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 299

Улаанбаатар  
хот

### Сургалтын агуулга, хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 29.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга”-ыг 1 дүгээр хавсралт, “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-ийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан сургалтын агуулга, хөтөлбөрийг хэрэгжүүлэн, ажлын тайланг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Удирдлагын академи (С.Зулпхар)-д даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

Засгийн газрын 2019 оны 299 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

### ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН БОГИНО БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ СУРГАЛТЫН АГУУЛГА

Нэг. Төрийн албан хаагчийн богино  
хугацааны сургалтын агуулга

1.1. Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалт:

Зорилго

Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтын зорилго нь төрийн албанд анх томилогдсон иргэнийг төрийн албаны онцлог, үйл ажиллагааны зарчим, хэм хэмжээ, эрх зүйн болон төрийн үйлчилгээний стандарт, шаардлагад нийцэн ажиллах мэдлэг чадвар эзэмшүүлэхэд оршино.





#### Агуулга

Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтын агуулга нь төрийн албаны онцлог, үнэт зүйлс, захирах захирагдах ёс, дүрэм, журам, хөгжлийн бодлого, стратегийн баримт бичиг, төрийн байгууллагын чиг үүрэг, төлөвлөлт, тайлагнал, төрийн албан хаагчийн ёс зүй, албан ажлын зохион байгуулалт, хариуцлага, мэдээллийн аюулгүй байдал, харилцааны соёл, жендерийн мэдрэмж болон хүний эрхийн чиглэлтэй байна.

#### Үр дүн

Сургалтын үр дүнд төрийн албанд анх томилогдсон албан хаагч төрийн албаны талаарх үндсэн мэдлэг чадварыг эзэмшсэний үндсэн дээр төрийн албыг хашихад эхний үед үүсч болзошгүй бэрхшээлийг хялбар даван туулах, албан үүргээ тогтоосон хэм хэмжээний дагуу, зохих ёсоор эрхлэх нөхцөл бүрдэнэ.

#### 1.2. Төрийн албан хаагчийн богино хугацааны зорилтот сургалт:

##### Зорилго

Төрийн албан хаагчийн богино хугацааны зорилтот сургалтын зорилго нь төрийн албан хаагчдад цаг үеийн эрэлт шаардлагад нийцсэн мэдлэг чадварыг тасралтгүй, шуурхай олгоход оршино.

##### Агуулга

Төрийн албан хаагчийн богино хугацааны зорилтот сургалтын агуулгыг цаг үеийн эрэлт шаардлага, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөлийн захиалгыг үндэслэн Удирдлагын академи төлөвлөж хэрэгжүүлнэ.

#### Үр дүн

Сургалтын үр дүнд төрийн албан хаагч албан тушаалын чиг үүргээ илүү сайн гүйцэтгэхэд нь шаардагдах тодорхой мэдлэг, ур чадварыг тухай бүр богино хугацаанд эзэмшсэний үндсэн дээр хариуцсан ажил, чиглэлээрээ мэргэшиж ажлын гүйцэтгэл, үр нөлөө нь дээшилнэ.

#### Хоёр. Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтын агуулга

#### 2.1. Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт:

##### Зорилго

Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтын зорилго нь төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад хамрагдсан төрийн захиргааны туслах, дэс түшмэлийн ангиллын албан тушаалд 1 жил ажилласан албан хаагчдад албан тушаалын чиг үүргээ амжилттай гүйцэтгэхэд шаардлагатай өргөн хүрээний мэдлэг чадварыг эзэмшүүлэхэд оршино.

#### Агуулга

Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтын агуулга нь Монгол Улсын Үндсэн хууль, төр, засгийн тогтолцоо, захиргааны болон хөдөлмөрийн харилцааны эрх зүйн үндсэн ойлголт, төрийн албан хаагчийн ёс зүйн мэдлэг, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зан үйл, албан хэрэг хөтлөлт, албан ажлын төлөвлөлт, бичиг баримт, шийдвэрийн боловсруулалт, хууль, эрх зүйн хэрэглээ, мэдээллийн технологи ашиглалт болон эрхэлсэн асуудлын хүрээнд мэдээлэл цуглуулах, боловсруулалт хийх арга зүй, илтгэх, тайлбарлах, тайлагнах, харилцах ур чадварын чиглэлтэй байна.

#### Үр дүн

Сургалтын үр дүнд төрийн албан хаагч албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвар, арга зүйг илүү өргөн хүрээнд эзэмшиж хариуцсан ажлаа мэргэжлийн зохих түвшинд үр бүтээлтэй хийж гүйцэтгэх нөхцөл бүрдэнэ.

2.2. Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт:

#### Зорилго

Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтын зорилго нь төрийн албан хаагчдад эрхэлж байгаа албан тушаалынх нь онцлог, гүйцэтгэж байгаа чиг үүрэг, хариуцсан ажлын шаардлагад нь нийцсэн мэдлэг чадварыг үе шаттайгаар тогтмол хөгжүүлж мэргэшүүлэхэд оршино.

#### Агуулга

Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтын агуулга нь төрийн захиргааны байгууллагын үндсэн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай төрийн бодлого, бодлого төлөвлөлт, зохицуулалт, захиргаа, хүний нөөц, төрийн санхүү, төсөв, хяналт-шинжилгээ, үнэлгээ, нутгийн удирдлага, байгууллагын удирдлагын талаарх мэдлэг болон байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хянах, хамт олныг удирдах, манлайлах, багаар ажиллах, оновчтой шийдвэр гаргах, дүн шинжилгээ хийх, ур чадварын чиглэлтэй байна.

#### Үр дүн

Сургалтын үр дүнд төрийн захиргааны байгууллагын бүтэц, чиг үүргийн дагуу хариуцсан ажил үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг чадварыг үе шаттайгаар эзэмшинэ.



Засгийн газрын 2019 оны 299 дүгээр  
тогтоолын 2 дугаар хавсралт

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН БОГИНО БОЛОН ДҮНД  
ХУГАЦААНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

Нэг. Төрийн албан хаагчийн богино хугацааны  
сургалтын хөтөлбөр

1.1. Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх  
богино хугацааны сургалтын хөтөлбөр:

| №  | Сургах чиглэл  |
|----|--|
| 1. | Төрийн албаны онцлог, үнэт зүйлс   |
| 2. | Төрийн захиргаа, нутгийн удирдлага   |
| 3. | Монгол Улсын хөгжлийн бодлого, стратеги  |
| 4. | Төрийн байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт                                  |
| 5. | Төрийн албаны эрх зүйн зохицуулалт   |
| 6. | Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага, албан ажлын зохион байгуулалт, харилцааны соёл |
| 7. | Төрийн захиргаанд мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглах арга зүй                 |
| 8. | Төрийн албан дахь хүний эрх, жөндөрийн асуудал   |
|    | Нийт 40 цаг  |

Төрийн албанд анх томилогдсон албан хаагч дээр дурдсан чиглэлээр 40 цагийн чиглүүлэх сургалтад заавал хамрагдана.

1.2. Төрийн албан хаагчийн богино хугацааны зорилтот сургалтын хөтөлбөр:

Төрийн албан хаагчийн богино хугацааны зорилтот сургалтыг Засгийн газар, төрийн албаны төв байгууллага болон төрийн бусад байгууллагын захиалга, цаг үеийн эрэлт шаардлагад үндэслэн явуулна. Сургалтын хөтөлбөрийг захиалгын дагуу боловсруулж төрийн албан хаагчдыг тухай бүр хамруулна. Энэхүү сургалт нь 16-40 цагийн багтаамжтай байна.

Хоёр. Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтын хөтөлбөр

2.1. Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтын хөтөлбөр:

| №   | Сургах чиглэл  | Багц цаг | Сургалтын цаг |         |          |
|-----|--|----------|---------------|---------|----------|
|     |  |          | Бүгд          | Үүнээс  |          |
|     |  |          |               | Танхимд | Бие даах |
| 1.  | Төрийн захиргааны хөгжил, хандлага                                     | 1        | 40            | 16      | 24       |
| 2.  | Захиргааны эрх зүй   | 1        | 40            | 16      | 24       |
| 3.  | Монгол Улсын төр, захиргааны тогтолцоо                                 | 1        | 40            | 16      | 24       |
| 4.  | Захиргааны мэдээлэл цуглуулах, шинжилгээ хийх аргачлал                 | 1        | 40            | 16      | 24       |
| 5.  | Хүний эрх ба захиргаа  | 1        | 40            | 16      | 24       |
| 6.  | Төрийн албан хэргийн баримт бичиг боловсруулах                         | 1        | 40            | 16      | 24       |
| 7.  | Мэдээлэл, харилцаа холбооны технологийг төрийн албанд ашиглах арга зүй | 1        | 40            | 16      | 24       |
| 8.  | Авлига, ашиг сонирхлын зөрчил, төрийн албан хаагчийн ёс зүй            | 1        | 40            | 16      | 24       |
| 9.  | Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаа, эрх зүйн зохицуулалт       | 1        | 40            | 16      | 24       |
| 10. | Харилцааны соёл, ур чадвар   | 1        | 40            | 16      | 24       |
|     | Судлах багц цаг  | 10       |               |         |          |
|     | Төгсөлтийн шалгалт   | 1        | 40            |         |          |
|     | Нийт багц цаг  | 11       |               |         |          |

Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад хамрагдсан төрийн захиргааны туслах, дэс түшмэлийн ангиллын албан тушаалд 1 жил ажилласан албан хаагч дээр дурдсан чиглэлээр танхимын болон бие даах хэлбэрээр сургалтад хамрагдаж нийт 11 багц цагийг биелүүлнэ.

2.2. Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтын хөтөлбөр:



| №   | Сургах чиглэл                                      | Багц цаг | Сургалтын цаг |         |          |
|-----|--|----------|---------------|---------|----------|
|     |  |          | Бүгд          | Үүнээс  |          |
|     |  |          |               | Танхимд | Бие даах |
| I   | Төрийн захиргаа                                    |          |               |         |          |
| 1.  | Эрх зүйн баримт бичиг боловсруулах арга зүй        | 2        | 80            | 24      | 56       |
| 2.  | Захиргааны процесс                                 | 2        | 80            | 24      | 56       |
| 3.  | Төрийн үйлчилгээ                                   | 2        | 80            | 24      | 56       |
| 4.  | Төр, хувийн хэвшлийн түншлэл                       | 2        | 80            | 24      | 56       |
| 5.  | Харьцуулсан захиргаа                               | 2        | 80            | 24      | 56       |
| 6.  | Гэрээний удирдлага                                 | 2        | 80            | 24      | 56       |
| 7.  | Цахим засаглал                                     | 2        | 80            | 24      | 56       |
| 8.  | Удирдлагын мэдээллийн систем                       | 2        | 80            | 24      | 56       |
| II  | Төрийн бодлого                                     |          |               |         |          |
| 1.  | Үндэсний аюулгүй байдлын бодлого, хэрэгжилт        | 2        | 80            | 24      | 56       |
| 2.  | Төрийн бодлого, удирдлагын эрсдэл                  | 2        | 80            | 24      | 56       |
| 3.  | Монгол Улсын салбар хоорондын бодлогын зохицуулалт | 2        | 80            | 24      | 56       |
| 4.  | Монгол Улсын гадаад бодлого                        | 2        | 80            | 24      | 56       |
| 5.  | Монгол Улсын геополитикийн орчин                   | 2        | 80            | 24      | 56       |
| 6.  | Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, хэрэгжилт      | 2        | 80            | 24      | 56       |
| 7.  | Төрийн эдийн засгийн бодлого, зохицуулалт          | 2        | 80            | 24      | 56       |
| 8.  | Монгол Улсын эдийн засаг, хөгжил, хандлага         | 2        | 80            | 24      | 56       |
| 9.  | Нийгмийн бодлого                                   | 2        | 80            | 24      | 56       |
| 10. | Хүн ам, хөгжлийн бодлого, төлөвлөлт                | 2        | 80            | 24      | 56       |
| 11. | Монгол Улсын улс төрийн орчин                      | 2        | 80            | 24      | 56       |
| 12. | Монголын төрийн бодлогын уламжлал, сургамж         | 2        | 80            | 24      | 56       |
| III | Нутгийн удирдлага                                  |          |               |         |          |
| 1.  | Нутгийн захиргаа                                   | 2        | 80            | 24      | 56       |



|     |  |   |    |    |    |
|-----|--|---|----|----|----|
| 2.  | Нутгийн өөрийн удирдлага                               | 2 | 80 | 24 | 56 |
| 3.  | Орон нутгийн эдийн засаг, санхүүгийн удирдлага         | 2 | 80 | 24 | 56 |
| 4.  | Хот суурины удирдлага                                  | 2 | 80 | 24 | 56 |
| IV  | Төрийн байгууллагын удирдлага                          |   |    |    |    |
| 1.  | Төрийн байгууллагын стратегийн удирдлага               | 2 | 80 | 24 | 56 |
| 2.  | Төрийн байгууллагын гүйцэтгэлийн удирдлага             | 2 | 80 | 24 | 56 |
| 3.  | Төрийн байгууллагын бүтээмж, чанарын удирдлага         | 2 | 80 | 24 | 56 |
| 4.  | Төрийн байгууллагын маркетинг                          | 2 | 80 | 24 | 56 |
| 5.  | Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлага                | 2 | 80 | 24 | 56 |
| 6.  | Өөрчлөлтийн удирдлага                                  | 2 | 80 | 24 | 56 |
| V   | Бодлого төлөвлөлт, зохицуулалт                         |   |    |    |    |
| 1.  | Бодлого боловсруулалт, төлөвлөлт                       | 2 | 80 | 24 | 56 |
| 2.  | Бодлого зохицуулалт, хэрэгжилт                         | 2 | 80 | 24 | 56 |
| 3.  | Бодлогын баримт бичиг боловсруулах                     | 2 | 80 | 24 | 56 |
| 4.  | Бодлогын шинжилгээний аргууд                           | 2 | 80 | 24 | 56 |
| 5.  | Эдийн засгийн шинжилгээ                                | 2 | 80 | 24 | 56 |
| 6.  | Хэрэглээний статистик                                  | 2 | 80 | 24 | 56 |
| 7.  | Бодлого, хөтөлбөрийн гүйцэтгэлийн удирдлага            | 2 | 80 | 24 | 56 |
| 8.  | Салбарын стратеги                                      | 2 | 80 | 24 | 56 |
| VI  | Хяналт-шинжилгээ, үнэлгээ                              |   |    |    |    |
| 1.  | Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй                  | 2 | 80 | 24 | 56 |
| 2.  | Бодлогын үнэлгээ                                       | 2 | 80 | 24 | 56 |
| 3.  | Захиргааны хяналт, шалгалт                             | 2 | 80 | 24 | 56 |
| 4.  | Төрийн аудит   | 2 | 80 | 24 | 56 |
| VII | Хүний нөөц   |   |    |    |    |
| 1.  | Төрийн албаны хүний нөөцийн бодлого, зохион байгуулалт | 2 | 80 | 24 | 56 |



|      |  |   |    |    |    |
|------|--|---|----|----|----|
| 2.   | Төрийн байгууллагын хүний нөөцийн удирдлага              | 2 | 80 | 24 | 56 |
| 3.   | Төрийн албан хаагчийн манлайлал                          | 2 | 80 | 24 | 56 |
| 4.   | Төрийн албан хаагчийн ёс зүй                             | 2 | 80 | 24 | 56 |
| 5.   | Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны зохицуулалт | 2 | 80 | 24 | 56 |
| ҮIII | Төсөв, санхүү  |   |    |    |    |
| 1.   | Төрийн санхүү, төсөв                                     | 2 | 80 | 24 | 56 |
| 2.   | Төсвийн байгууллагын санхүүгийн удирдлага                | 2 | 80 | 24 | 56 |
| 3.   | Хөтөлбөр, төслийн удирдлага                              | 2 | 80 | 24 | 56 |
| 4.   | Төсвийн байгууллагын бүртгэл, аудит                      | 2 | 80 | 24 | 56 |
| 5.   | Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага                     | 2 | 80 | 24 | 56 |
| IX   | Удирдлагын арга барил                                    |   |    |    |    |
| 1.   | Байгууллагын хөгжил, өөрчлөлтийн удирдлага               | 2 | 80 | 24 | 56 |
| 2.   | Байгууллагын соёл, уур амьсгал                           | 2 | 80 | 24 | 56 |
| 3.   | Баг бүрдүүлэх, багаар ажиллах                            | 2 | 80 | 24 | 56 |
| 4.   | Шийдвэр гаргах   | 2 | 80 | 24 | 56 |
| 5.   | Хэлэлцээр, зөвшилцлийн арга барил                        | 2 | 80 | 24 | 56 |
| 6.   | Төрийн байгууллагын гадаад харилцаа, дипломат ёс         | 2 | 80 | 24 | 56 |
| 7.   | Нийгмийн сэтгэл зүй                                      | 2 | 80 | 24 | 56 |
| 8.   | Олон нийтийн харилцаа                                    | 2 | 80 | 24 | 56 |
| 9.   | Олон нийтийн оролцоо, аудит                              | 2 | 80 | 24 | 56 |
| 10.  | Инноваци, мэдлэгийн менежмент                            | 2 | 80 | 24 | 56 |
| 11.  | Харилцааны ур чадвар                                     | 2 | 80 | 24 | 56 |

Төрийн албан хаагч энэхүү хөтөлбөрийн 2.1-д заасан “Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-ийн дагуу сургалтад хамрагдсанаас хойш 3 жил тутамд албан тушаалынхаа чиг үүргийн дагуу дээр дурдсан чиглэлээс сонгон 8 багц цагийн хичээлийг судалж, төгсөлтийн шалгалт (1 багц цаг) өгч, нийт 9 багц цагийг биелүүлэн суралцана.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 7 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар 303

Улаанбаатар  
хот

### **“Ирээдүйн өв сан корпораци” байгуулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 13.3, 18.1, 18.7, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ирээдүйн өв сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх үүрэг бүхий “Ирээдүйн өв сан корпораци”-ийг хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулсугай.

2. “Ирээдүйн өв сан корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

3. “Ирээдүйн өв сан корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааг эхлүүлэх үеийн тохирсон бүтцийг бий болгох болон Ирээдүйн өв сангийн хөрөнгийн удирдлагыг хариуцуулах, зардлын хязгаарыг тогтоох асуудлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт даалгасугай.

4. “Ирээдүйн өв сан корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулсан тухай шийдвэрийг Улсын Их Хуралд танилцуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**САНГИЙН САЙД**

**Ч.ХҮРЭЛБААТАР**

Засгийн газрын 2019 оны 303 дугаар  
тогтоолын хавсралт

### **“ИРЭЭДҮЙН ӨВ САН КОРПОРАЦИ” ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ**

I БҮЛЭГ. КОРПОРАЦИ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрэм нь (цаашид “Дүрэм” гэх) “Ирээдүйн өв сан корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эрх зүйн байдал,





үйл ажиллагааны чиглэл, удирдлага, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлсон үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг байна.

1.2. “Ирээдүйн өв сан корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид “Корпораци” гэх) нь Ирээдүйн өв сангийн тухай хууль (цаашид “Хууль” гэх), Монгол Улсын Үндсэн хууль, Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.3. Корпораци нь Хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу Ирээдүйн өв сан (цаашид “Сан” гэх)-ийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх, үүрэг бүхий ашгийн төлөө хуулийн этгээд байна.

#### Хоёр. Корпорацийн оноосон нэр, хаяг

2.1. Корпорацийн оноосон нэр нь монгол хэл дээр “Ирээдүйн өв сан корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компани, товчилсон нэр нь “ИӨСК” ХХК, англи хэл дээр “FUTURE HERITAGE FUND CORPORATION” LLC, товчилсон нэр “FHFC” LLC байна.

2.2. Корпорацийн байршил нь Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын II байрны “Д” корпус буюу Монгол Улсын Сангийн яамны байранд байрлах бөгөөд корпорацийн хаягийг зохих журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

2.3. Корпораци нь өөрийн бэлгэдэл, барааны тэмдэгтэй байж болох бөгөөд зохих журмын дагуу бүртгүүлэн хэрэглэнэ.

2.4. Корпораци нь удирдах зөвлөлөөс баталсан албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.

#### Гурав. Корпорацийн үйл ажиллагааны зарчим

3.1. Корпораци нь Сангийн үр өгөөжийг тогтвортой хангаж, үнэ цэнийг өсгөхийг эрмэлзэх бөгөөд Хуулийн 5 дугаар зүйлд заасан хараат бус байх, ил тод байх, Сангийн хөрөнгийг зохистой удирдах, Сангийн хөрөнгийг үр ашигтай удирдах, хариуцлагатай байх зарчмыг үйл ажиллагаандаа баримтална.

3.2. Энэ дүрмийн 3.1-т заасан зарчмыг Хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу хэрэгжүүлнэ.

3.3. Корпораци нь үйл ажиллагаандаа энэ дүрмийн 3.1-д зааснаас гадна олон улсын үндэсний баялгийн сангийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмыг баримтална.

### Дөрөв. Корпорацийн үйл ажиллагааны чиглэл

4.1. Корпораци нь Хуульд заасны дагуу зөвхөн Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх бөгөөд Засгийн газраас итгэмжлүүлсэн тохиолдолд Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

#### Тав. Корпорацийн бүрэн эрх

5.1. Корпораци нь Хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу зохион байгуулагдах, бие даасан тайлан тэнцэлтэй, Монголбанкинд төгрөгийн болон валютын харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх, үүрэг бүхий хуулийн этгээд байх бөгөөд хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж түүнийг захиран зарцуулах эрх нь Хууль, энэ дүрмээр хязгаарлагдах хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр ажиллана.

5.2. Корпораци нь гэрээ, хэлцэл байгуулах, эдийн болон эдийн бус хөрөнгийн эрх олж авах, үүрэг хүлээх, шүүх, арбитрын үйл ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч болон гуравдагч этгээдээр оролцох эрхтэй.

5.3. Корпораци нь Сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах үүргийн хүрээнд Санг төлөөлөн шүүх, арбитрын үйл ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох эрхтэй.

5.4. Корпораци нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байрлах бөгөөд удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт болон гадаад улсад салбар, төлөөлөгчийн газартай байж болно.

5.5. Корпорацийн салбар, төлөөлөгчийн газрын удирдлагыг удирдах зөвлөлөөс томилох бөгөөд Корпорациас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.

5.6. Корпораци нь өдөр тутмын үйл ажиллагаа явуулах, төлбөр тооцоо хийх зорилгоор бусад арилжааны банкинд төгрөг болон валютын данстай байж болно.

#### Зургаа. Корпорацийн хувь нийлүүлсэн хөрөнгө

6.1. Корпорацийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 1,000,000 (нэг сая) төгрөг байна.

6.2. Корпорацийн нийт гаргасан болон зарласан хувьцааны тоо нь 1 (нэг) ширхэг энгийн хувьцаа бөгөөд нэг ширхэг энгийн хувьцаа нь 1,000,000 (нэг сая) төгрөгийн нэрлэсэн үнэтэй байна.

6.3. Корпораци нь хувьцаа эзэмшигчийн бусад компани, хуулийн этгээд болон тэдгээрийн үйл ажиллагаанаас тусдаа, бие даан үйл



ажиллагаа эрхлэх бөгөөд Корпорацийн үйл ажиллагааг Хууль болон энэ дүрмээр зохицуулна.

#### Долоо. Корпорацийн эрх хэмжээний хязгаар

7.1. Корпораци нь Хууль, энэ дүрэмд заасан эрх хэмжээг хэрэгжүүлж, Хуулийн 10, 11 дүгээр зүйлд заасан мандат, хөрөнгө оруулалтын стратегийн хүрээнд үйл ажиллагаа явуулах бөгөөд Хуульд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

7.2. Корпораци болон Сангийн аливаа хөрөнгийг улс төрийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, түүнд нөлөөлөх зорилгоор ашиглахыг хориглоно.

## II БҮЛЭГ. КОРПОРАЦИЙН УДИРДЛАГА

### Найм. Хувьцаа эзэмшигч

8.1. Корпорацийн үүсгэн байгуулагч бөгөөд хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын Засгийн газар байх бөгөөд Корпорацийг үүсгэн байгуулах, татан буулгах, Хуульд нийцүүлэн дүрмийг батлах, өөрчлөлт оруулах эрхтэй байна.

### Ес. Удирдах зөвлөл

9.1. Корпорацийн эрх барих дээд байгууллага нь Хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу таван гишүүнээс бүрдсэн удирдах зөвлөл (цаашид “Удирдах зөвлөл” гэх) байна.

9.2. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Хуулийн 20.8-д заасны дагуу нэр дэвшүүлэх хорооноос сонгосон этгээдийг удирдах зөвлөлийн гишүүнээр 5 жилийн хугацаагаар томилж, гэрээ байгуулна.

9.3. Удирдах зөвлөлийн даргыг удирдах зөвлөлийн гишүүд дотроос нийт гишүүдийн олонхын саналаар 2 жилийн хугацаатай сонгоно.

9.4. Удирдах зөвлөлийн дарга нь удирдах зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах, даргалах, хуралдааны тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ.

9.5. Удирдах зөвлөлийн дарга хуралдааны чөлөөт цагт гүйцэтгэх удирдлага, удирдах зөвлөлийг холбох үүрэг хүлээнэ.

9.6. Удирдах зөвлөлийн дарга нь хүндэтгэн үзэх шалтгаанаар үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон, чөлөөлөгдсөн тохиолдолд удирдах зөвлөлөөс урьдчилан сонгосон гишүүн хуралдааныг даргална.

9.7. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн удирдах зөвлөлийн гишүүнийг Хуулийн 21.4 дэх хэсэг болон гэрээнд заасан үндэслэлээр чөлөөлж болно. Энэ тохиолдолд чөлөөлөх шийдвэрт үндэслэлийг тодорхой заана.

9.8. Энэ дүрмийн 9.7-д заасан тохиолдолд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага удирдах зөвлөлийн гишүүдийг нөхөн томилж ажлыг нэн даруй зохион байгуулна.

9.9. Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг удирдах зөвлөлийн даргын санал болгосноор удирдах зөвлөлөөс томилно.

Арав. Удирдах зөвлөлийн хуралдаан

10.1. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааныг сард нэг удаа товлон хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хуралдаан хийж болно.

10.2. Хуралдааны дэгийг удирдах зөвлөл батална.

10.3. Удирдах зөвлөл нь хуралдаанаар гүйцэтгэх удирдлагын тайлан мэдээлэл, шаардлагатай гэж үзсэн бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

10.4. Удирдах зөвлөлийн гишүүдийн олонх оролцсоноор хуралдаан хүчин төгөлдөр болно. Удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг эчнээ санал хураалтаар авч болох бөгөөд удирдах зөвлөлийн гишүүн саналаа бичгээр хүргүүлсэн тохиолдолд хуралдаанд оролцож, хүчин төгөлдөр санал өгсөнд тооцно.

10.5. Удирдах зөвлөлийн хуралдааныг энэ дүрмийн 10.4-т зааснаас гадна телеконференц эсхүл, видео конференцийн хэлбэрээр хийж болно.

10.6. Хуулийн 22.1.1-д заасан Сангийн хөрөнгө оруулалтын стратегийг удирдах зөвлөлийн нийт гишүүдийн 100 хувийн саналаар батлах бөгөөд ийнхүү батлаагүй тохиолдолд ажлын 10 хоногийн дотор дахин хуралдаж гишүүдийн дийлэнх олонхын саналаар батална.

10.7. Энэ дүрмийн 10.6-д зааснаас бусад асуудлыг удирдах зөвлөлийн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.

Арван нэг. Удирдах зөвлөлийн бүрэн эрх

11.1. Удирдах зөвлөл нь Хуулийн 22 дугаар зүйлд зааснаас гадна холбогдох хууль тогтоомж, энэ дүрэмд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.



11.2. Удирдах зөвлөл нь Сангийн хөрөнгө оруулалтын стратегид дараахь зүйлийг тусган батална:

11.2.1. Гадаад, дотоод менежерийн удирдах хөрөнгийн харьцаа;

11.2.2. актив болон пассив хөрөнгө оруулалтын стратегийн харьцаа;

11.2.3. хөрөнгө оруулалтын менежер, портфолио буюу багц санхүүгийн хөрөнгийн тоо хэмжээ, төрөл;

11.2.4. шаардлагатай бусад зүйл.

11.3. Удирдах зөвлөл энэ дүрмийн 11.2-т заасан харьцааг өөрчлөн тогтоож болно.

11.4. Удирдах зөвлөл нь дараахь асуудалд тогтмол хяналт тавина:

11.4.1. Сангийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, хөрөнгийн ангилал, хөрөнгө оруулалтын менежер бөгөөд портфолио, Сангийн хөрөнгийг удирдах зардал;

11.4.2. хөрөнгийн байршуулалт, Сангийн хөрөнгө оруулалтын эрсдэл;

11.4.3. Корпораци нь үйл ажиллагаагаа удирдах зөвлөл болон эрх бүхий этгээдээс тогтоосон дүрэм журмын хүрээнд явуулж байгаа эсэх.

11.5. Удирдах зөвлөл үндсэн үйлчилгээ үзүүлэх дараахь этгээдтэй гэрээ байгуулан ажиллуулах зөвшөөрлийг гүйцэтгэх удирдлагад олгож, гүйцэтгэл, үйлчилгээний түвшин, төлбөр зэрэгт хяналт тавина:

11.5.1. аудитор;

11.5.2. кастодиан;

11.5.3. хөрөнгө оруулалтын менежер;

11.5.4. хөрөнгө оруулалтын зөвлөх;

11.5.5. Удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад этгээд.

Арван хоёр. Удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

12.1. Удирдах зөвлөл нь аудитын хороо, хөрөнгө оруулалтын хороотой байх бөгөөд тэдгээрийн бүтэц, ажиллах журмыг батална.

12.2. Удирдах зөвлөлөөс тусгай чиг үүрэг бүхий түр хороог байгуулж болно. Түр хороо нь удирдах зөвлөлд тайлагнаж ажиллах бөгөөд тусгайлан эрх хэмжээ олгосноос бусад асуудлаар шийдвэр гаргах эрхгүй. Түр хорооны ажиллах хугацааг удирдах зөвлөлөөс сунгаснаас бусад тохиолдолд байгуулагдсанаас хойш нэг жилийн дараа эсвэл зорилго биелэгдсэнээр татан буугдана.

### Арван гурав. Аудитын хороо

13.1. Аудитын хороонд санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэдлэгтэй, санхүүгийн тайланг хянах чадвар бүхий нэгээс доошгүй удирдах зөвлөлийн гишүүнийг томилно.

13.2. Удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо дараахь чиг үүрэгтэй байна:

13.2.1. Сангийн болон корпорацийн санхүүгийн тайлагналын үйл явц, дотоод хяналтын үнэн зөв эсэхэд болон санхүү, нягтлан бодох бүртгэл, хууль эрх зүйн нийцлийн байдлыг хянах;

13.2.2. Сангийн хөндлөнгийн аудиторын гүйцэтгэл болон хараат бус байдлыг хянах;

13.2.3. хөндлөнгийн аудитор болон гүйцэтгэх удирдлага, удирдах зөвлөлийг өөрийн чиг үүрэгт хамаарах мэдээллээр хангах;

13.2.4. хуульд заасан шаардлага хангасан аудиторыг томилох.

13.3. Аудитын хороо нь жилд 2-оос доошгүй удаа хуралдана.

13.4. Шаардлагатай тохиолдолд холбогдох менежер, аудитор болон бусад албан тушаалтныг хуралд оролцуулж, мэдээлэл авч болно.

13.5. Аудитын хороо Удирдах зөвлөлд тогтмол тайлагнаж ажиллана.

### Арван дөрөв. Хөрөнгө оруулалтын хороо

14.1. Хөрөнгө оруулалтын хороонд удирдах зөвлөлийн гишүүдийн нэгээс доошгүй гишүүнийг томилно.

14.2. Хөрөнгө оруулалтын хороо дараахь чиг үүрэгтэй байна:

14.2.1. Хуулийн 12.3 дахь хэсэгт заасан зээл авах шийдвэрийг гаргах, эсхүл зээлийн хэмжээг тогтоох;

14.2.2. хөрөнгө оруулалтын стратегийн төслийг хянах;

14.2.3. удирдах зөвлөлөөс тогтоосон бусад чиг үүрэг.

14.3. Гүйцэтгэх удирдлага хөрөнгө оруулалтын стратегийн төслийг жил бүр шинэчлэн боловсруулж, дараахь тайлан, мэдээллийг хавсарган Хөрөнгө оруулалтын хороонд хүргүүлнэ:

14.3.1. тухайн төсвийн жил дэх хөрөнгө оруулалтын стратегийн төлөвлөгөөний биелэлт;

14.3.2. хэрэгжиж байгаа төсөл болон дараагийн төсвийн жилд хэрэгжүүлэх шинэ санал санаачилга.



14.4. Хөрөнгө оруулалтын хороо хөрөнгө оруулалтын стратегийн төслийг хянаж, шаардлагатай тодорхой өөрчлөлтийг тусган удирдах зөвлөлөөр батлуулахаар хүргүүлнэ.

#### Арван тав. Гүйцэтгэх удирдлага

15.1. Гүйцэтгэх удирдлага нь Корпорацийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Гүйцэтгэх удирдлагыг удирдах зөвлөлийн шийдвэрээр хувь хүн, эсхүл багаар хэрэгжүүлж болно.

15.2. Удирдах зөвлөл нь гүйцэтгэх удирдлагатай гурван жилийн хугацаатай гэрээ байгуулах бөгөөд гэрээг сунгаж болно.

15.3. Удирдах зөвлөл Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээг Хууль, энэ дүрэм болон гэрээнд заасан үндэслэлээр хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.

15.4. Удирдах зөвлөлөөс зөвшөөрснөөс бусад тохиолдолд гүйцэтгэх захирал, эсхүл гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч багийн гишүүн нь өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад давхар ажиллахыг хориглоно.

15.5. Гүйцэтгэх удирдлага нь Хуулийн 25.13 дахь хэсэгт заасан болон холбогдох хууль тогтоомж, энэ дүрэмд заасан бусад эрх, үүрэгтэй байна.

15.6. Корпораци хөрөнгө оруулалтын, эрсдэлийн удирдлагын, дотоод хяналтын асуудал хариуцсан дотоод бүтцийн нэгжтэй байх бөгөөд гүйцэтгэх удирдлага нь Корпорацийн бүтцийг боловсруулж удирдах зөвлөлөөр батлуулна.

15.7. Гүйцэтгэх удирдлага нь удирдах зөвлөлөөс тогтоосон төсөв, бодлого, дотоод хяналтын хүрээнд зарлага хийх эрхтэй байна.

15.8. Гүйцэтгэх удирдлагын бүх шийдвэрийг удирдах зөвлөлөөс баталсан төсвийн хязгаарт нийцүүлэн гаргах бөгөөд хууль тогтоомж болон удирдах зөвлөлөөс баталсан холбогдох дүрэм, журамд нийцсэн байна.

15.9. Гүйцэтгэх удирдлага Корпорацийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлөн гэрээ, хэлцэл хийх эрхтэй. Хууль болон энэ дүрэмд нийцээгүй, зөрчсөн аливаа хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

15.10. Гүйцэтгэх удирдлага энэ дүрмийн 11.5-д заасан үндсэн үйлчилгээ үзүүлэх этгээдийг томилуулахаар удирдах зөвлөлд санал оруулна.

15.11. Гүйцэтгэх удирдлага энэ дүрмийн 15.10-т зааснаас бусад үйлчилгээ үзүүлэх этгээдийг томилно.



15.12. Гүйцэтгэх удирдлага нь удирдах зөвлөлийг шаардлагатай мэдээ, мэдээллээр цаг тухайд нь хангаж ажиллана.

15.13. Гүйцэтгэх удирдлага энэ дүрмийн 11.5-д заасан этгээдийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллана.

15.14. Гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээ дараахь үндэслэлээр дуусгавар болно:

15.14.1. гэрээний хугацаа дуусгавар болсон;

15.14.2. Хуулийн 25.14 дэх хэсэгт заасан шаардлагыг хангахгүй болсон;

15.14.3. эрүүл мэндийн болон бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас гэрээг дуусгавар болгох хүсэлт гаргасан;

15.14.4. гэмт хэрэгт холбогдож, гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон;

15.14.5. Сангийн эрх ашигт харшлах үйлдэл, эс үйлдэл гаргасан нь тогтоогдсон;

15.14.6. Хуульд заасан журмыг зөрчин сонирхлын зөрчилтэй хэлцэл хийж, Корпорацид хохирол учруулсан;

15.14.7. Хууль болон гэрээнд заасан бусад үндэслэл.

15.15. Энэ дүрмийн 15.14-д заасны дагуу гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээ дуусгавар болсон тохиолдолд удирдах зөвлөл энэ талаар нэн даруй санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ.

15.16. Гүйцэтгэх удирдлага Корпорацийн дотоод журмыг хууль тогтоомж болон энэ дүрэмд нийцүүлэн баталж мөрдүүлнэ.

15.17. Гүйцэтгэх удирдлага нь Корпораци, түүний дотоод хяналтын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, энэ дүрмийн дагуу хяналт тавьж ажиллана.

### III БҮЛЭГ. КОРПОРАЦИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, АЖИЛТАН

Арван зургаа. Корпорацийн эрх бүхий албан тушаалтан

16.1. Корпорацийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог дараахь этгээдийг Корпорацийн эрх бүхий албан тушаалтанд тооцно:

16.1.1. удирдах зөвлөлийн гишүүн;

16.1.2. гүйцэтгэх захирал;

16.1.3. гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн;

16.1.4. удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга;

16.1.5. ерөнхий нягтлан бодогч.





16.2. Эрх бүхий албан тушаалтан нь өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээллийг удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад тухайн албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногт багтаан хүргүүлэх бөгөөд уг мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдол бүрт холбогдох мэдээллийг 10 хоногийн дотор хүргүүлнэ.

16.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан дараахь үүрэгтэй:

16.3.1. хууль тогтоомж, энэ дүрэм болон холбогдох бусад дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд эрх, үүргээ хэрэгжүүлэх;

16.3.2. Корпорацийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж ажиллах;

16.3.3. шууд болон шууд бус байдлаар Корпорацийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох аливаа хэлцэл, үйл ажиллагааны талаар удирдах зөвлөлд шуурхай мэдэгдэх;

16.3.4. Корпорацийн эрх ашигт нийцсэн, үндэслэлтэй шийдвэр гаргах;

16.3.5. сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, сонирхлын зөрчил үүсч болзошгүй тохиолдолд тухай бүр удирдах зөвлөл, аудиторт мэдэгдэх;

16.3.6. Корпорацийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлоор ашиглахгүй байх.

16.4. Корпорацийн эрх бүхий албан тушаалтан албан тушаалаасаа өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн хугацаанд энэ дүрмийн 16.3.6-д заасан үүргийг хүлээнэ.

Арван долоо. Корпорацийн ажилтан

17.1. Корпорацийн ажилтан Корпорацийн ашиг сонирхлыг хангуулахыг эрмэлзэж, дотоод журмын дагуу эрх, үүргээ хэрэгжүүлж, ёс зүйн дүрмийг дагаж мөрдөнө.

17.2. Гүйцэтгэх удирдлага Корпорацийн бүтэц, цалин хангамж, бусад зардлыг батлагдсан төсвийн хүрээнд тогтоон ажиллана.

17.3. Гүйцэтгэх удирдлага нь удирдах зөвлөлөөс баталсан бүтэц, төсвийн хүрээнд ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулна.

17.4. Корпораци баталсан төсвөөс давсан санхүүжилт шаардсан өндөр ур чадвар бүхий ажилтныг томилох, шинээр ажлын байр бий болгох зэрэг асуудлыг удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлнэ.



#### IV БҮЛЭГ. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ТАЙЛАН

##### Арван найм. Корпорацийн төсөв

18.1. Гүйцэтгэх удирдлага нь Корпорацийн дараа жилийн төсвийн төсөөллийг боловсруулж, тухайн оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор удирдах зөвлөлд хүргүүлнэ.

18.2. Төсвийн төсөлд дараахь зүйлийг тусгана:

18.2.1. төсвийн зүйл бүрээр задаргааг томоохон зардлын төрлөөр нь дарааллуулан;

18.2.2. төсвийн зүйл бүрээр тухайн жилийн батлагдсан төсөвтэй хийсэн харьцуулалт болон тухайн жилийн бодит зарцуулалт;

18.2.3. төсвийн зүйл нь тухайн жилийн төсвөөс зөрүүтэй бол түүний тайлбар;

18.2.4. дараагийн төсвийн жилд хэрэгжүүлэхээр тооцсон төсөл, санал санаачилгын зардлын хэмжээ;

18.2.5. бусад шаардлагатай зүйл.

18.3. Удирдах зөвлөл Корпорацийн дараа жилийн төсвийг хянаж, тухайн оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор батална.

18.4. Гүйцэтгэх удирдлага улирал бүр тухайн жилийн батлагдсан төсвийн гүйцэтгэлийг дараахь байдлаар гаргаж удирдах зөвлөлд тайлагнана:

18.4.1. батлагдсан төсвийн зарцуулалт;

18.4.2. бодит зарцуулалт;

18.4.3. батлагдсан төсөв, бодит зарцуулалтын зөрүү зарцуулалт бүрээр.

##### Арван ес. Төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт

19.1. Удирдах зөвлөл нь төсөв, санхүүгийн хяналт шалгалт, тайлагналын бодлого, тайланд тавигдах шаардлагыг тогтооно.

19.2. Корпораци нь холбогдох хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, удирдах зөвлөлд танилцуулна. Гүйцэтгэх удирдлага Корпорацийн нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна.

19.3. Гүйцэтгэх удирдлага нь Сангийн улирлын болон жилийн тайлан гаргах ажлыг удирдан зохион байгуулж, хяналт тавина.



19.4. Гүйцэтгэх удирдлага нь Хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу сангийн болон корпорацийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтэд зохих тайлбарыг бэлтгэн Аудитын хороотой зөвлөлдөнө.

19.5. Хөндлөнгийн аудитын шалгалтаар Корпорацийн эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанаас шалтгаалсан зөрчил илэрсэн тохиолдолд тухайн албан тушаалтан зөрчлийн талаарх тайлбарыг гаргаж 1 сарын дотор удирдах зөвлөлд хүргүүлнэ. Ийнхүү гаргаагүй тохиолдолд хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

19.6. Хөндлөнгийн аудитын зардлыг Хуулийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу Сангийн хөрөнгөөс санхүүжүүлнэ.

19.7. Корпорацийн санхүүгийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж мөн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

19.8. Корпораци нь Монгол Улсын хуулиар чөлөөлснөөс бусад татварыг төлнө.

19.9. Сангийн болон корпорацийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг төгрөгөөр илэрхийлнэ. Сангийн хөрөнгө түүний дотор банкны данс, орлого, зарлага болон зээлийг анх хөрөнгө оруулалт хийсэн валютаар бүртгэж, Монголбанкны албан ёсны ханшийг ашиглана.

#### Хорь. Тайлан, ил тод байдал

20.1. Удирдах зөвлөл нь Сангийн санхүү, үйл ажиллагааны тайланг Хуулийн 28 дугаар зүйлд заасан хугацаанд тайлагнаж байгаа эсэхэд хяналт тавина.

20.2. Гүйцэтгэх удирдлага нь санхүүгийн ил тод байдлыг хангуулах, тайлан мэдээллийг гаргах чиглэлээр дараахь арга хэмжээ авна:

20.2.1. жилийн орлогын болон хөрөнгийн төсвийг санхүүгийн жил эхлэхээс өмнө боловсруулж, хүргүүлэх;

20.2.2. тайлангийн хугацаанд Корпорацийн бүтэц зохион байгуулалт, эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, өөрчлөлт, үр дүнгийн талаарх мэдээллээр бэлтгэн хүргүүлэх;

20.2.3. тайлангийн хугацаанд Корпорацийн эрх бүхий албан тушаалтанд олгосон шагнал урамшуулал, удирдлагын зардлын хэмжээг тайлагнах;

20.2.4. удирдах зөвлөл болон тэдгээрийн эрх олгосон төлөөлөгчдийг Корпорацийн тайлан тооцоо, нягтлан бодох бүртгэлд хяналт шалгалт хийх боломж нөхцөлөөр хангах, эсхүл баримт, материал бэлтгэн хүргүүлэх;

20.2.5. Удирдах зөвлөлийг менежментийн болон санхүүгийн мэдээллээр хангах;

20.2.6. Корпорацийн улирал, жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан болон удирдах зөвлөлөөс шаардсан бусад баримт, материал, мэдээллийг хүссэн хэлбэрээр (цахим, хэвлэмэл, эсхүл факс зэрэг) хүргүүлэх.

20.3. Корпораци нь Сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг Хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тухай бүр нийтэд ил тод мэдээлнэ.

## V БҮЛЭГ. БУСАД

Хорин нэг. Корпорацийн үйл ажиллагаа  
явуулах хугацаа

21.1. Корпораци нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

Хорин хоёр. Корпорацийн хөрөнгийн  
эрхийн бүртгэл

22.1. Корпораци эзэмшиж байгаа аливаа хөрөнгийг зохих журмын дагуу бүртгүүлж, санхүүгийн тайлан баланстаа тусгана.

22.2. Корпораци өөрийн байгууллагын бэлгэдэл, барааны тэмдэг зэрэг оюуны өмчийг зохих журмын дагуу оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.

22.3. Энэ дүрмийн 22.2-т заасан оюуны өмчийг шаардлагатай бол гадаад улсын оюуны өмчийн байгууллагад бүртгүүлж болно.

22.4. Сангийн хөрөнгийг Корпорацийн хөрөнгөөс тусгаарласан байна.



## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

### МОНГОЛ УЛС БОЛОН ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ ХООРОНДЫН САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР

“Эдийн засгийн удирдлагыг дэмжих хөтөлбөр”-ийн  
Хоёр дахь шатны Хөгжлийн бодлогын санхүүжилт)

ЗЭЭЛИЙН ДУГААР 6471-МН

### САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү Хэлэлцээрийг Монгол Улс (“Хүлээн авагч”) болон Олон улсын хөгжлийн ассоциаци (“Ассоциаци”) хоорондын Хөтөлбөр (энэхүү Хэлэлцээрийн Хавсралтад тодорхойлсон)-т санхүүгийн дэмжлэг үзүүлэх үүднээс Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдөр байгуулав.

Улмаар (А) Хүлээн авагчийн зүгээс Хүлээн авагч болон Банк хооронд энэхүү өдөр байгуулсан зээлийн гэрээний хүрээнд (“Зээлийн гэрээ”) уг Хөтөлбөрийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хорин сая ам.доллар (\$20,000,000)-той тэнцэх үнийн дүн бүхий зээлийг Банкаас хүссэн; ба

(Б) Ассоциаци нь (i) энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 1-ийн Хэсэг I-д заагдсан, мөн Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдийг Хүлээн авагч бүрэн хэрэгжүүлсэн; мөн (ii) Хүлээн авагчийн макро-эдийн засгийн бодлогын хэрэгжилт зохистой түвшинд байна гэж үзсэн тул энэхүү санхүүжилтийг олгохоор шийдвэрлэсэн.

Иймд, Хүлээн авагч болон Ассоциаци хооронд дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов. Үүнд:

### 1 ДҮГЭЭР ЗҮЙЛ — ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ, НЭР ТОМЬЁО

- 1.01. Ерөнхий нөхцөлүүд нь (энэхүү Хэлэлцээрийн Хавсралтад заагдсан) энэхүү Хэлэлцээрт үйлчлэх ба түүний салшгүй хэсэг байна.
- 1.02. Хэлэлцээрийн агуулгад өөрөөр заагаагүй бол Хэлэлцээрт том үсгээр тэмдэглэсэн нэр томьёонууд Ерөнхий нөхцөлүүд эсхүл энэхүү Хэлэлцээр (мөн түүний Удиртгал болон Хавсралтад)-т заасан утгыг илэрхийлнэ.

## 2 ДУГААР ЗҮЙЛ — САНХҮҮЖИЛТ

- 2.01. Ассоциаци нь Хүлээн авагчид тавин найман сая нэг зуун мянган Зээлжих тусгай эрх (ЗТЭ 58,100,000)-тэй тэнцэхүйц санхүүжилтийг (түүнчлэн “Зээл” болон “Санхүүжилт” гэх) хөнгөлөлттэй нөхцөлөөр (Ерөнхий нөхцөлүүдийн хувьд) олгохыг зөвшөөрсөн.
- 2.02. Санхүүжилтийн ашиглагдаагүй үлдэгдэлд тооцогдох хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийн дээд хэмжээ жилийн нэг хувийн хагас (1%-ийн 1/2) байна.
- 2.03. Зээлийн ашигласан үлдэгдэлд тооцогдох үйлчилгээний хураамж жилийн нэг хувийн дөрөвний гурав (1%-ийн 3/4) байна.
- 2.04. Зээлийн ашигласан үлдэгдэлд тооцогдох зээлийн хүү жилийн нэг зууны хорин таван хувь (1.25%) байна.
- 2.05. Төлбөр хийх өдөр жил бүрийн 4 дүгээр сарын 15 болон 10 дугаар сарын 15-ны өдөр байна.
- 2.06. Үндсэн зээлийг энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-т заасан эргэн төлөгдөх хуваарийн дагуу эргэн төлнө.
- 2.07. Төлбөр гүйцэтгэх мөнгөн тэмдэгт АНУ-ын доллар байна.
- 2.08. Ерөнхий нөхцөлүүдийн Хэсэг 5.05-д зааснаас гадна Хүлээн авагч Ассоциацид энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд хамаарах мэдээллийг хүссэн даруйд бэлдэж өгнө.

## 3 ДУГААР ЗҮЙЛ — ХӨТӨЛБӨР

- 3.01. Хүлээн авагч Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн болохоо зөвшөөрч буй. Улмаар Ерөнхий нөхцөлүүдийн Хэсэг 5.05-д заасны дагуу:
  - (а) Хүлээн авагч болон Ассоциацийн аль нэг талын хүсэлтээр шаардлагатай тохиолдолд Хүлээн авагчийн макро-эдийн засгийн бодлогын хэрэгжилт болон Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын талаар харилцан санал солилцоно;
  - (б) ийнхүү харилцан санал солилцохын өмнө Хүлээн авагч Хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн явцын талаар дэлгэрэнгүй тайлан бэлтгэн, Ассоциацид хянуулах, санал авах зорилгоор хүргүүлнэ;
  - (в) энэ хэсгийн (а) болон (б)-д заасан заалтуудаас гадна энэхүү Хөтөлбөрийн зорилт эсхүл Хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн, Хэлэлцээрийн Хуваарь 1-ийн Хэсэг I-д тусгасан аливаа арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж болзошгүй ямарваа нэгэн нөхцөл байдал үүсэх тохиолдолд Хүлээн авагч энэ тухай Ассоциацид нэн даруй мэдэгдэнэ.



#### **4 ДҮГЭЭР ЗҮЙЛ — АССОЦИАЦИАС АВАХ ХАМГААЛЛЫН АРГА ХЭМЖЭЭ**

- 4.01. Хөтөлбөрийг бүхэлд нь эсхүл түүний дийлэнх хэсгийг хэрэгжүүлэх боломжгүй болох тохиолдолд Хэлэлцээрийн үйлчлэлийг түр зогсоох нэмэлт нөхцөл байдал үүснэ.

#### **5 ДУГААР ЗҮЙЛ — ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ; ЦУЦЛАХ**

- 5.01. Хүчин төгөлдөр болох Нэмэлт нөхцөлүүдэд:
- (а) Ассоциаци нь Хүлээн авагчийн зүгээс Хөтөлбөрийг хэрэгжилтэд гаргасан ахиц дэвшил болон Хүлээн авагчийн макро-эдийн засгийн бодлогын хэрэгжилт зохистой түвшинд байна гэж үзсэн байх.
  - (б) Ассоциаци нь Хүлээн авагчийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг арилжааны банкуудын дахин хөрөнгөжүүлсэн эх үүсвэрийг магадлан баталгаажуулах шалгалт хийлгэх зорилгоор Монголбанк болон хараат бус аудитор (Ассоциациас хүлээн зөвшөөрсөн ажлын даалгавар, удирдамжид нийцсэн, тавигдсан шаардлагуудыг хангаж буй) хооронд зохих журмын дагуу үйлдэгдсэн гэрээний хуулбарыг хүлээн авсан байх; ба
  - (в) Зээлийн гэрээг байгуулж, хүчин төгөлдөр болгох эсхүл зээлийн хөрөнгийг ашиглах Зээлдэгчийн эрхийг нээхэд (энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос бусад) тавигдах урьдчилсан нөхцөлүүд бүгд хангагдсан байна.
- 5.02. Энэхүү Хэлэлцээр Хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь Хэлэлцээр байгуулагдсан өдрөөс нэг зуун хорин (120) хоногийн дотор байна.
- 5.03. Ерөнхий нөхцөлүүдийн Хэсэг 10.05 (б)-ийн дагуу Хүлээн авагчийн энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хүлээх үүрэг хариуцлага (төлбөрийн үүрэг хариуцлагаас бусад) Хэлэлцээр байгуулагдсан өдрөөс хорин (20) жилийн дараа дуусгавар болно.

#### **6 ДУГААР ЗҮЙЛ — ТӨЛӨӨЛӨГЧ; ХАЯГ**

- 6.01. Хүлээн авагчийн төлөөлөгч нь түүний Сангийн сайд байна.
- 6.02. Ерөнхий нөхцөлүүдийн Хэсэг 11.01-ийн хувьд
- (а) Хүлээн авагчийн хаяг:

Сангийн яам  
Засгийн газрын II дугаар байр  
С.Данзангийн гудамж 5/1Д  
Улаанбаатар хот, 15160  
Монгол Улс ба

(б) Хүлээн авагчийн цахим хаяг:

Факсын дугаар: 976-11-320247

6.03. Ерөнхий нөхцөлүүдийн Хэсэг 11.01-ийн хувьд

(а) Ассоциацийн хаяг:

Олон улсын хөгжлийн ассоциаци

1818 H Street, N.W.

Washington, D.C. 20433

United States of America ба

(б) Ассоциацийн цахим хаяг:

Телекс: Факс:

248423 (MCI) 1-202-477-6391

Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдөр ХАРИЛЦАН ТОХИРОЛЦОВ.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ

\_\_\_\_\_ Эрх бүхий төлөөлөгч

Нэр: **Чимэдийн Хүрэлбаатар**

Албан тушаал: **Сангийн сайд**

Огноо: **2019 оны 9 дүгээр сарын 13**

ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИЙГ ТӨЛӨӨЛЖ

\_\_\_\_\_ Эрх бүхий төлөөлөгч

Нэр: **Андрей Михнев**

Албан тушаал: **Дэлхийн банкны Монгол дахь Суурин төлөөлөгч**

Огноо: **2019 оны 9 дүгээр сарын 13**

## ХУВААРЬ 1

**Хөтөлбөрийн арга хэмжээ;**

**Санхүүжилтийн хөрөнгийн бэлэн байдал**

### **Хэсэг I. Хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

Хүлээн авагчийн зүгээс Хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд:

#### **А. Өрийн тогтвортой байдлыг сэргээх**

1. Хүлээн авагч нь Монгол Улсын Хөгжлийн банкны 2012-2017 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн этгээдээр тусгайлсан дүн шинжилгээ хийлгэсэн нь Монгол Улсын Хөгжлийн банкны 2018 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн Санхүүгийн дүн шинжилгээгээр нотлогдож буй; дүн шинжилгээг Монгол Улсын Хөгжлийн банкны албан ёсны цахим хуудаснаа байршуулсныг 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдөр татаж үзсэн.





2. Хүлээн авагч нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийг тогтвортой тогтолцоо бүрдүүлэх хөтөлбөр”-ийг шинэчилж, Монголбанкийг уг хөтөлбөрөөс гаргах хугацаатай төлөвлөгөөг Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 285/А-334 хамтарсан тушаалаар батлуулсан.
3. Хүлээн авагч нь Монголбанкны Төсвийн шинжтэй буюу Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр, Үнэ тогтворжуулах хөтөлбөр, компаниудад үзүүлж буй санхүүгийн дэмжлэг зэрэг хөтөлбөр, арга хэмжээнд хөндлөнгийн тусгайлсан үнэлгээ хийлгэж, үнэлгээний тайланг (2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн) Монголбанкны албан ёсны цахим хуудаснаа байршуулан, олон нийтэд ил болгосныг 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдөр татаж үзсэн.
4. Хүлээн авагч нь 2020 оны төсвийн жилээс эхлэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн үр нөлөөг дээшлүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж, Сангийн сайдын 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 99 дүгээр тушаалаар “Татварын зарлагын /хөнгөлөлт, чөлөөлөлт/ үр нөлөөг дээшлүүлэх, татварын зарлагын төсөөллийг хийх, гүйцэтгэлийг тайлагнах журам”-ыг батлуулсан.
5. Хүлээн авагч нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй болон шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр ашгийг дээшлүүлж, зардлыг бууруулах үүднээс Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн 295 дугаар тушаалаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ыг батлуулсан.
6. Хүлээн авагч нь Засгийн газрын Тусгай сангуудын эрх зүйн, засаглалын болон хяналт, шалгалтын зохицуулалтыг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраар 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 87 дугаар тогтоолоор “Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээ”-г хэлэлцүүлэн батлуулсан.

**Б. Нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх**

7. Хүлээн авагч нь 2019 оны төсвийн жилд Хүнсний талон хөтөлбөр болон ядуурлыг бууруулахад чиглэсэн бусад хөтөлбөрт хуваарилах төсвийг нэмэгдүүлж, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 309 дугаар тушаалаар 2019 оны төсвийн хуваарийг батлуулсан.

**В. Эдийн засгийн өрсөлдөх чадварыг дэмжих**

8. Хүлээн авагч нь төрийн захиргааны байгууллагуудын олгодог бүх тусгай зөвшөөрөл, лицензийг жагсаан, тэдгээрийн тоог багасгах үүднээс Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Хууль зүйн сайд нарын хамтарсан тушаалаар батлагдсан Хуулийн төслийн үзэл баримтлалын хамт Улсын Их Хуралд 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн.

9. Хүлээн авагч нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс хуулийг даган гарах эрх зүйн зохицуулалтын хүрээнд малын өвчлөлгүй бүс байгуулах, олон улсын хорио цээрийн журмыг мөрдүүлэх, хил дамнасан малын өвчнийг хянах стратеги төлөвлөгөө батлах, хуулийн хүрээнд малчдын хүлээх үүргийг баталгаажуулах зэрэг харилцааг зохицуулсан багц журам, дүрэм болон удирдамжийг батлуулсан. Үүнд: (а) ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн А-40 дугаар тушаалаар батлагдсан “Халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон мэдээлэх журам”; (б) Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”; ба (в) Мал эмнэлэг, үржлийн газрын даргын 2018 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн А/17 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан мал эмнэлэг, хорио цээрийн зааварчилгаа.
10. Хүлээн авагч нь Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох уг хэлэлцээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах, байгууллага хоорондын зохицуулалтын механизмыг бүрдүүлэх; болон худалдааны нэгдсэн мэдээллийн сан үзсэн байгуулах үүрэг хүлээснээ биелүүлсэн: (а) Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооноос 2018 оны 10 дугаар сарын 4-ний өдөр баталсан 2018-2022 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө; б) Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны 2019 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 4 дүгээр хуралдааны шийдвэр; (в) Гадаад харилцааны сайд, Сангийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А/27/28 дугаар хамтарсан тушаал.

**Хэсэг II. Санхүүжилтийг татан авах нөхцөл**

- А. Ерөнхий.** Хүлээн авагч нь Санхүүжилт татан авахтай холбоотой энэхүү хэсэг дэх заалтууд болон Ассоциациас Хүлээн авагчид бичгээр хүргүүлэх нэмэлт зааврын дагуу санхүүжилтийг татан авч болно.
- Б. Санхүүжилтийн хуваарилалт.** Санхүүжилтийг нэг удаагийн татан авалтаар ашиглах хуваарилалт хийсэн ба Хүлээн авагч ийнхүү санхүүжилтийн татан авснаар хөрөнгийг ашиглах боломж бүрдэнэ. Санхүүжилтийн хуваарилалтыг доорх хүснэгтэд харуулсан:

| Хуваарилалт                  | Санхүүжилтийн хуваарилалт<br>(ЗТЭ-ээр илэрхийлэгдсэн) |
|------------------------------|---|
| (1) Нэг удаагийн татан авалт | ЗТЭ 58,100,000  |
| НИЙТ ДҮН                     | ЗТЭ 58,100,000  |

**В. Татан авалт хийх нөхцөл.**

Хүлээн авагч нь Санхүүжилтийг (а) Хүлээн авагчийн хэрэгжүүлж байгаа Хөтөлбөрийн хэрэгжилт; болон (б) Хүлээн авагчийн макро-эдийн засгийн бодлогын хэрэгжилт зохистой түвшинд байгаа болохыг Ассоциаци баталгаажуулсан нөхцөлд татан авах боломжтой болно.

**Г. Санхүүжилтийн мөнгийг хадгалах.**

1. Хүлээн авагч нь Санхүүжилтийг данснаас татан авснаас гуч (30) хоногийн дараа Ассоциацид дараах байдлаар тайлагнана: (а) Ерөнхий нөхцөлүүдийн Хэсэг 2.03 (а)-ын дагуу хүлээн авсан мөнгөн дүн; (б) Санхүүжилтийг Монгол төгрөг хэлбэрээр хүлээн авах дансны дэлгэрэнгүй мэдээлэл; (в) Хүлээн авагчийн төсвийн удирдлагын системд энэхүү мөнгөн дүнг бүртгэсэн бүртгэл; болон (г) Ерөнхий нөхцөлүүдийн Хэсэг 2.03 (а)-д заасан дансны холбогдолтой баримт, ашиглалын тайлан.

- Д. **Хаалтын хугацаа.** Хаалтын хугацаа 2020 оны 7 дугаар сарын 23-ны өдөр.

**ХУВААРЬ 2**

Эргэн төлөлтийн хуваарь

| Төлбөр хийгдэх огноо  | Үндсэн зээлийн эргэн төлөх дүн<br>(хувиар илэрхийлсэн)* |
|---|---|
| Жил бүрийн 4 дүгээр сарын 15 ба 10 дугаар сарын 15;                         |   |
| 2024 оны 10 дугаар сарын 15-наас эхлэн<br>2044 оны 4 дүгээр сарын 15 хүртэл | 1.65%   |
| 2044 оны 10 дугаар сарын 15-наас эхлэн<br>2049 оны 4 дүгээр сарын 15 хүртэл | 3.40%   |

\* Үндсэн зээлийн эргэн төлөх дүн нь Ерөнхий нөхцөлүүдийн Хэсэг 3.05 (б)-д өөрөөр зааснаас бусад тохиолдолд хувиар илэрхийлэгдэнэ.

**ХАВСРАЛТ****Тодорхойлолтууд**

1. “МБ” гэж Хүлээн авагчийн Төв банкны тухай хуулийн дагуу 1996 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр байгуулагдсан Хүлээн авагчийн Монголбанк эсхүл түүний аливаа залгамжлагчийг хэлнэ.
2. “Засгийн газрын тогтоол” гэж Хүлээн авагчийн Засгийн газраас гаргасан тогтоолыг хэлнэ.
3. “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж Хүлээн авагчийн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар эсхүл түүний аливаа залгамжлагчийг хэлнэ.



4. “МУХБ” гэж Хүлээн авагчийн Хөгжлийн банкны тухай хуулийн дагуу 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдөр байгуулагдсан Монгол Улсын Хөгжлийн банк эсхүл түүний аливаа залгамжлагчийг хэлнэ.
5. “Хүнсний талон хөтөлбөр” гэж Хүлээн авагчийн Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу байгуулагдсан, нийгмийн нэн ядуу, эмзэг бүлгийн гэр бүлүүдэд хүнс, тэжээлийн тусламж олгох зорилго бүхий хүнсний талон хөтөлбөрийг хэлнэ.
6. “Ерөнхий нөхцөлүүд” гэж 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан “Олон улсын хөгжлийн ассоциацийн Хөгжлийн бодлогын санхүүжилтийн Ерөнхий нөхцөлүүд”-ийг хэлнэ.
7. “Засгийн газрын тусгай сан” гэж Хүлээн авагчийн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдан үйл ажиллагаа явуулдаг улсын төсвөөс санхүүждэг тусгай санг хэлнэ.
8. “Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр” гэж Хүлээн авагчийн Монголбанкны Ерөнхийлөгч, Барилга хот байгуулалтын сайд нарын 2013 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн А-2/06 дугаар хамтарсан тушаалаар байгуулж, хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцны ипотекийн зээл олгох хөтөлбөрийг хэлнэ.
9. “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль” гэж 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Хүлээн авагчийн УИХ-аас батлагдсан нэр бүхий хууль ба түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг хэлнэ.
10. “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль” гэж 2017 оны 12 дугаар сарын 8-ны өдөр Хүлээн авагчийн УИХ-аас баталсан нэр бүхий хууль ба түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг хэлнэ.
11. “Монгол төгрөг” нь Хүлээн авагчийн албан ёсны мөнгөн тэмдэгтийг хэлнэ.
12. “Улсын Их Хурал” гэж Хүлээн авагчийн төрийн эрх барих дээд байгууллага эсхүл түүний аливаа залгамжлагчийг хэлнэ.
13. “Хөтөлбөр” гэж Хүлээн авагчийн хэрэгжүүлэх энэхүү Хэлэлцээрт тусгасан зорилго, бодлого, арга хэмжээг болон Хэлэлцээрийн Хуваарь 1-ийн Хэсэг 1-д заасан, хөтөлбөрийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг эрэлхийлэн Хүлээн авагчаас 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Ассоциацид хүргүүлсэн албан захидалд дурдагдсан арга хэмжээ бүхий хөтөлбөрийг хэлнэ.
14. “Үнэ тогтворжуулах хөтөлбөр” гэж Хүлээн авагчийн Засгийн газар, Монголбанкны хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийг хамтран хэрэгжүүлэх үүднээс байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу Хүлээн авагчийн хэрэгжүүлж буй хөтөлбөрийг хэлнэ.
15. “Гарын үсэг зурсан өдөр” гэж энэхүү Хэлэлцээрт Ассоциаци болон Хүлээн авагч талын аль сүүлд гарын үсэг зурсан өдрийг хэлэх бөгөөд энэхүү тодорхойлолт нь Ерөнхий нөхцөлүүдэд тусгагдсан



- “Санхүүжилтийн хэлэлцээрийн огноо» гэсэн нэр томъёонд мөн хамаарна.
16. “Нийгмийн халамжийн тухай хууль” гэж 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Хүлээн авагчийн УИХ-аас баталсан нэр бүхий хууль ба түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг хэлнэ.
  17. “Нэг удаагийн татан авалт” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 1-ийн Хэсэг II-ийн Б дэх хүснэгтэд “Нэг удаагийн татан авалт” гэсэн ангилалд хуваарилагдсан санхүүжилтийн хэмжээг хэлнэ.
  18. “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр” гэж худалдааг хөнгөвчлөх зорилгоор Дэлхийн худалдааны байгууллагын бүх гишүүн орнууд (Хүлээн авагчийг оролцуулан) баталсан, 2017 оны 2 дугаар сарын 22-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж буй хэлэлцээрийг хэлнэ.

## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

### МОНГОЛ УЛС

### БОЛОН

### ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК

### ХООРОНДЫН ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ

**(“Эдийн засгийн удирдлагыг дэмжих хөтөлбөр”-ийн  
Хоёр дахь шатны Хөгжлийн бодлогын санхүүжилт)**

### ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ

Энэхүү Гэрээг Монгол Улс (“Зээлдэгч”) болон Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк (“Банк”) хооронд Хөтөлбөр (энэхүү Гэрээний Хавсралтад тодорхойлсон)-т санхүүгийн дэмжлэг үзүүлэх үүднээс Гэрээнд гарын үсэг зурсан өдөр байгуулав.

Улмаар (А) Зээлдэгчийн зүгээс Зээлдэгч болон Ассоциаци хооронд энэхүү өдөр байгуулсан санхүүжилтийн хэлэлцээрийн хүрээнд (“Санхүүжилтийн хэлэлцээр”) уг Хөтөлбөрийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор тавин найман сая нэг зуун мянган Зээлжих тусгай эрх (ЗТЭ 58,100,000)-тэй тэнцэх үнийн дүн бүхий санхүүжилт Ассоциациас хүссэн; ба

(Б) Банк нь энэхүү Гэрээ болон дээрх Санхүүжилтийн хэлэлцээрийг үндэслэн (i) энэхүү Гэрээний Хуваарь 1-ийн Хэсэг 1-д заагдсан, мөн Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдийг Зээлдэгч бүрэн хэрэгжүүлсэн; ба (ii) Хүлээн авагчийн макро-эдийн засгийн бодлогын хэрэгжилт зохистой түвшинд байна гэж үзсэн тул энэхүү санхүүжилтийг олгохоор шийдвэрлэсэн.

Иймд, Зээлдэгч болон Банк хооронд дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов.  
Үүнд:

### **1 ДҮГЭЭР ЗҮЙЛ — ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ, НЭР ТОМЬЁО**

- 1.01. Ерөнхий нөхцөлүүд нь (энэхүү Гэрээний Хавсралтад заагдсан) энэхүү Гэрээнд үйлчлэх ба түүний салшгүй хэсэг байна.
- 1.02. Гэрээний агуулгад өөрөөр заагаагүй бол Гэрээнд том үсгээр тэмдэглэсэн нэр томьёонууд Ерөнхий нөхцөлүүд эсхүл энэхүү Гэрээ (мөн түүний Удиртгал болон Хавсралтад)-т заасан утгыг илэрхийлнэ.

### **2 ДУГААР ЗҮЙЛ — ЗЭЭЛ**

- 2.01. Банк нь Зээлдэгчид хорин сая (\$20,000,000) ам.доллар /шаардлагатай тохиолдолд өөр валютад хөрвүүлэх боломжтой/-той тэнцэхүйц зээлийг (“Зээл”) олгохыг зөвшөөрсөн.
- 2.02. Урьдчилсан хураамж нь Зээлийн нэг хувийн дөрөвний нэг (0.25%) байна.
- 2.03. Зээлийн ашиглагдаагүй үлдэгдэлд тооцогдох хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийн дээд хэмжээ жилийн нэг хувийн хагас (1%-ийн 1/2) байна.
- 2.04. Зээлийн хүү харилцан тохирсон жишиг хувь дээр хувьсах хүүгийн хувь хэмжээ эсхүл хөрвүүлсэн (Ерөнхий нөхцөлүүдийн 3.02 (д)-д заасан) хэмжээг нэмсэнтэй тэнцэнэ.
- 2.05. Төлбөр хийх өдөр жил бүрийн 4 дүгээр сарын 15 болон 10 дугаар сарын 15-ны өдөр байна.
- 2.06. Үндсэн зээлийг Хуваарь 2-т заасан эргэн төлөгдөх хуваарийн дагуу эргэн төлнө.
- 2.07. Ерөнхий нөхцөлүүдийн Хэсэг 5.05-д зааснаас гадна Зээлдэгч Банканд энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд хамаарах мэдээллийг хүссэн даруйд бэлдэж өгнө.

### **3 ДУГААР ЗҮЙЛ — ХӨТӨЛБӨР**

- 3.01. Зээлдэгч Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн болохоо зөвшөөрч буй. Улмаар Ерөнхий нөхцөлүүдийн Хэсэг 5.05-д заасны дагуу:
  - (а) Зээлдэгч болон Банкны аль нэг талын хүсэлтээр шаардлагатай тохиолдолд Зээлдэгчийн макро-эдийн засгийн бодлогын хэрэгжилт болон Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын талаар харилцан санал солилцоно;
  - (б) энэ хэсгийн (а)-д зааснаас гадна энэхүү Хөтөлбөрийн зорилт эсхүл Хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн,



Хэлэлцээрийн Хуваарь 1-ийн Хэсэг I-д тусгасан аливаа арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж болзошгүй ямарваа нэгэн нөхцөл байдал үүсэх тохиолдолд Зээлдэгч энэ тухай Банканд нэн даруй мэдэгдэнэ.

#### **4 ДҮГЭЭР ЗҮЙЛ — БАНКНААС АВАХ ХАМГААЛЛЫН АРГА ХЭМЖЭЭ**

- 4.01. Хөтөлбөрийг бүхэлд нь эсхүл түүний дийлэнх хэсгийг хэрэгжүүлэх боломжгүй болох тохиолдолд Гэрээний үйлчлэлийг түр зогсоох нэмэлт нөхцөл байдал үүснэ.

#### **5 ДУГААР ЗҮЙЛ — ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ; ЦУЦЛАХ**

- 5.01. Хүчин төгөлдөр болох Нэмэлт нөхцөлүүдэд:
- (а) Банк нь Зээлдэгчийн зүгээс Хөтөлбөрийг хэрэгжилтэд гаргасан ахиц дэвшил болон Зээлдэгчийн макро-эдийн засгийн бодлогын хэрэгжилт зохистой түвшинд байна гэж үзсэн байх.
  - (б) Банк нь Зээлдэгчийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг арилжааны банкуудын дахин хөрөнгөжүүлсэн эх үүсвэрийг магадлан баталгаажуулах шалгалт хийлгэх зорилгоор Монголбанк болон хараат бус аудитор (Банкнаас хүлээн зөвшөөрсөн ажлын даалгавар, удирдамжид нийцсэн, тавигдсан шаардлагуудыг хангаж буй) хооронд зохих журмын дагуу үйлдэгдсэн гэрээний хуулбарыг хүлээн авсан байх; ба
  - (в) Санхүүжилтийн хэлэлцээрийг байгуулж, хүчин төгөлдөр болгох эсхүл зээлийн хөрөнгийг ашиглах Хүлээн авагчийн эрхийг нээхэд (энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болохоос бусад) тавигдах урьдчилсан нөхцөлүүд бүгд хангагдсан байна.
- 5.02. Энэхүү Гэрээ Хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь Гэрээ байгуулагдсан өдрөөс нэг зуун хорин (120) хоногийн дотор байна.
- 5.03. Ерөнхий нөхцөлүүдийн Хэсэг 9.05 (б)-ийн дагуу Зээлдэгчийн энэхүү Гэрээний хүрээнд хүлээх үүрэг хариуцлага (төлбөрийн үүрэг хариуцлагаас бусад) Гэрээ байгуулагдсан өдрөөс хорин (20) жилийн дараа дуусгавар болно.

#### **6 ДУГААР ЗҮЙЛ — ТӨЛӨӨЛӨГЧ; ХАЯГ**

- 6.01. Зээлдэгчийн төлөөлөгч нь түүний Сангийн сайд байна.
- 6.02. Ерөнхий нөхцөлүүдийн Хэсэг 11.01-ийн хувьд

(а) Зээлдэгчийн хаяг:

Сангийн яам  
Засгийн газрын II дугаар байр  
С.Данзангийн гудамж 5/1Д  
Улаанбаатар хот, 15160  
Монгол Улс ба

(б) Зээлдэгчийн цахим хаяг:

Факсын дугаар: 976-11-320247

6.03. Ерөнхий нөхцөлүүдийн Хэсэг 11.01-ийн хувьд (а) Банкны хаяг:

Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк  
1818 H Street, N.W.  
Washington, D.C. 20433  
United States of America ба

(б) Банкны цахим хаяг:

Телекс: 248423 (MCI) эсвэл 64145 (MCI) Факс: 1-202-477-6391

Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөр ХАРИЛЦАН ТОХИРОЛЦОВ.

**МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ**

Эрх бүхий төлөөлөгч

Нэр: **Чимэдийн Хүрэлбаатар**

Албан тушаал: **Сангийн сайд**

**Огноо: 2019 оны 9 дүгээр сарын 13**

**ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИЙГ ТӨЛӨӨЛЖ**

Эрх бүхий төлөөлөгч

Нэр: **Андрей Михнев**

Албан тушаал: **Дэлхийн банкны Монгол дахь Суурин төлөөлөгч**

**Огноо: 2019 оны 9 дүгээр сарын 13**

## **ХУВААРЬ 1**

**Хөтөлбөрийн арга хэмжээ;**

**Санхүүжилтийн хөрөнгийн бэлэн байдал**

**Хэсэг I. Хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

Хүлээн авагчийн зүгээс Хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд:

**A. Өрийн тогтвортой байдлыг сэргээх**

1. Хүлээн авагч нь Монгол Улсын Хөгжлийн банкны 2012-2017 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн этгээдээр тусгайлсан дүн шинжилгээ





хийлгэсэн нь Монгол Улсын Хөгжлийн банкны 2018 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн Санхүүгийн дүн шинжилгээгээр нотлогдож буй; дүн шинжилгээг Монгол Улсын Хөгжлийн банкны албан ёсны цахим хуудаснаа байршуулсныг 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдөр татаж үзсэн.

2. Хүлээн авагч нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийг тогтвортой тогтолцоо бүрдүүлэх хөтөлбөр”-ийг шинэчилж, Монголбанкийг уг хөтөлбөрөөс гаргах хугацаатай төлөвлөгөөг Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 285/А-334 хамтарсан тушаалаар батлуулсан.
3. Хүлээн авагч нь Монголбанкны Төсвийн шинжтэй буюу Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр, Үнэ тогтворжуулах хөтөлбөр, компаниудад үзүүлж буй санхүүгийн дэмжлэг зэрэг хөтөлбөр, арга хэмжээнд хөндлөнгийн тусгайлсан үнэлгээ хийлгэж, үнэлгээний тайланг (2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн) Монголбанкны албан ёсны цахим хуудаснаа байршуулан, олон нийтэд ил болгосныг 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдөр татаж үзсэн.
4. Хүлээн авагч нь 2020 оны төсвийн жилээс эхлэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн үр нөлөөг дээшлүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж, Сангийн сайдын 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 99 дүгээр тушаалаар “Татварын зарлагын /хөнгөлөлт, чөлөөлөлт/ үр нөлөөг дээшлүүлэх, татварын зарлагын төсөөллийг хийх, гүйцэтгэлийг тайлагнах журам”-ыг батлуулсан.
5. Хүлээн авагч нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй болон шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр ашгийг дээшлүүлж, зардлыг бууруулах үүднээс Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 295 дугаар тушаалаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ыг батлуулсан.
6. Хүлээн авагч нь Засгийн газрын Тусгай сангуудын эрх зүйн, засаглалын болон хяналт, шалгалтын зохицуулалтыг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраар 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 87 дугаар тогтоолоор “Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээ”-г хэлэлцүүлэн батлуулсан.

**Б. Нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх**

7. Хүлээн авагч нь 2019 оны төсвийн жилд Хүнсний талон хөтөлбөр болон ядуурлыг бууруулахад чиглэсэн бусад хөтөлбөрт хуваарилах төсвийг нэмэгдүүлж, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 309 дугаар тушаалаар 2019 оны төсвийн хуваарийг батлуулсан.

**В. Эдийн засгийн өрсөлдөх чадварыг дэмжих**

8. Хүлээн авагч нь төрийн захиргааны байгууллагуудын олгодог

- бүх тусгай тусгай зөвшөөрөл, лицензийг жагсаан, тэдгээрийн тоог багасгах үүднээс Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга болон Хууль зүйн сайд нарын хамтарсан тушаалаар батлагдсан Хуулийн төслийн үзэл баримтлалын хамт Улсын Их Хуралд 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн.
9. Хүлээн авагч нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс хуулийг даган гарах эрх зүйн зохицуулалтын хүрээнд малын өвчлөлгүй бүс байгуулах, олон улсын хорио цээрийн журмыг мөрдүүлэх, хил дамнасан малын өвчнийг хянах стратеги төлөвлөгөө батлах, хуулийн хүрээнд малчдын хүлээх үүргийг баталгаажуулах зэрэг харилцааг зохицуулсан багц журам, дүрэм болон удирдамжийг батлуулсан. Үүнд: (а) ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн А-40 дугаар тушаалаар батлагдсан “Халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон мэдээлэх журам”; (б) Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”; ба (в) Мал эмнэлэг, үржлийн газрын даргын 2018 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн А/17 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан мал эмнэлэг, хорио цээрийн зааварчилгаа.
10. Хүлээн авагч нь Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох уг хэлэлцээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах, байгууллага хоорондын зохицуулалтын механизмыг бүрдүүлэх; болон худалдааны нэгдсэн мэдээллийн сан үүсгэн байгуулах үүрэг хүлээснээ биелүүлсэн: (а) Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооноос 2018 оны 10 дугаар сарын 4-ний өдөр баталсан 2018-2022 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө; б) Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны 2019 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 4 дүгээр хуралдааны шийдвэр; (в) Гадаад харилцааны сайд, Сангийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А/27/28 дугаар хамтарсан тушаал.

## **Хэсэг II. Зээл татан авах нөхцөл**

- А. Ерөнхий.** Зээлдэгч нь энэхүү хэсэг дэх Зээлийн хөрөнгийг татан авах заалтууд болон Банкнаас Зээлдэгчид бичгээр хүргүүлсэн нэмэлт зааврыг үндэслэн зээлийн хөрөнгийг татан авч болно.
- Б.** Зээлийн хуваарилалт. Зээл [урьдчилсан хураамжаас бусад]-ийг нэг удаагийн татан авалтаар ашиглах хуваарилалт хийсэн ба Зээлдэгч ийнхүү зээлийн санхүүжилтийг татан авснаар хөрөнгийг ашиглах боломж бүрдэнэ. Зээлийн хөрөнгийн хуваарилалтыг доорх хүснэгтэд харуулсан:



| Хуваарилалт   | Зээлийн хөрөнгийн хуваарилалт<br>(ам.доллороор илэрхийлэгдсэн) |
|---|--|
| (1) Нэг удаагийн санхүүжилт                             | \$19,950,000   |
| (2) Урьдчилсан хураамж                                  | \$50,000   |
| (3) Ерөнхий нөхцөлүүдийн Хэсэг 4.05-д заасан мөнгөн дүн | 0  |
| <b>НИЙТ ДҮН</b>   | <b>\$20,000,000</b>  |

**В. Татан авалт хийх нөхцөл.**

Зээлдэгч нь Зээлийн хөрөнгийг (а) Зээлдэгчийн хэрэгжүүлж байгаа Хөтөлбөрийн хэрэгжилт; болон (б) Зээлдэгчийн макро-эдийн засгийн бодлогын хэрэгжилт зохистой түвшинд байгаа болохыг Банк баталгаажуулсан нөхцөлд татан авах боломжтой болно.

**Г. Зээлийн мөнгийг хадгалах.**

1. Зээлдэгч нь Зээлийн хөрөнгийг данснаас татан авснаас гуч (30) хоногийн дараа Банканд дараах байдлаар тайлагнана: (а) Ерөнхий нөхцөлүүдийн Хэсэг 2.03 (а)-ын дагуу хүлээн авсан мөнгөн дүн; (б) зээлийн хөрөнгийг Монгол төгрөг хэлбэрээр хүлээн авах дансны дэлгэрэнгүй мэдээлэл; (в) Зээлдэгчийн төсвийн удирдлагын системд энэхүү мөнгөн дүнг бүртгэсэн бүртгэл; болон (г) Ерөнхий нөхцөлүүдийн Хэсэг 2.03 (а)-д заасан дансны холбогдолтой баримт, ашиглалын тайлан.

- Д. Хаалтын хугацаа. Хаалтын хугацаа 2020 оны 7 дугаар сарын 23-ны өдөр.

**ХУВААРЬ 2**

**Зээлийн ашиглалттай уясан эргэн төлөлтийн хуваарь**

\* Дараах хүснэгтэд Зээлийн үндсэн төлбөр хийгдэх өдрүүд болон тухайн төлбөр хийх өдөр тус бүр зээлийн хөрөнгөөс эргэн төлөгдөх хувь хэмжээг илэрхийлж буй (“Төлбөрийн хувь хэмжээ”).

**Үндсэн зээлийг ижил хэмжээгээр эргэн төлөх хуваарь**

| Үндсэн төлбөр хийгдэх огноо  | Төлбөрийн хувь хэмжээ |
|--|-----------------------|
| <b>Жил бүрийн 4 дүгээр сарын 15 ба 10 дугаар сарын 15</b>                |                       |
| 2024 оны 10 дугаар сарын 15-наас эхлэн 2049 оны 4 дүгээр сарын 15 хүртэл | 2%                    |

## **ХАВСРАЛТ** **Тодорхойлолтууд**

1. “МБ” гэж Хүлээн авагчийн Төв банкны тухай хуулийн дагуу 1996 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр байгуулагдсан Хүлээн авагчийн Монголбанк эсхүл түүний аливаа залгамжлагчийг хэлнэ.
2. “Засгийн газрын тогтоол” гэж Хүлээн авагчийн Засгийн газраас гаргасан тогтоолыг хэлнэ.
3. “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж Хүлээн авагчийн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар эсхүл түүний аливаа залгамжлагчийг хэлнэ.
4. “МУХБ” гэж Хүлээн авагчийн Хөгжлийн банкны тухай хуулийн дагуу 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдөр байгуулагдсан Монгол Улсын Хөгжлийн банк эсхүл түүний аливаа залгамжлагчийг хэлнэ.
5. “Хүнсний талон хөтөлбөр” гэж Хүлээн авагчийн Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу байгуулагдсан, нийгмийн нэн ядуу, эмзэг бүлгийн гэр бүлүүдэд хүнс, тэжээлийн тусламж олгох зорилго бүхий хүнсний талон хөтөлбөрийг хэлнэ.
6. “Ерөнхий нөхцөлүүд” гэж 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан “Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны Хөгжлийн бодлогын санхүүжилтийн Ерөнхий нөхцөлүүд”-ийг хэлнэ.
7. “Засгийн газрын тусгай сан” гэж Хүлээн авагчийн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдан үйл ажиллагаа явуулдаг улсын төсвөөс санхүүждэг тусгай санг хэлнэ.
8. “Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр” гэж Хүлээн авагчийн Монголбанкны Ерөнхийлөгч, Барилга хот байгуулалтын сайд нарын 2013 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн А-2/06 дугаар хамтарсан тушаалаар байгуулж, хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцны ипотекийн зээл олгох хөтөлбөрийг хэлнэ.
9. “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль” гэж 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Хүлээн авагчийн УИХ-аас батлагдсан нэр бүхий хууль ба түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг хэлнэ.
10. “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль” гэж 2017 оны 12 дугаар сарын 8-ны өдөр Хүлээн авагчийн УИХ-аас баталсан нэр бүхий хууль ба түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг хэлнэ.
11. “Монгол төгрөг” нь Хүлээн авагчийн албан ёсны мөнгөн тэмдэгтийг хэлнэ.
12. “Улсын Их Хурал” гэж Хүлээн авагчийн төрийн эрх барих дээд байгууллага эсхүл түүний аливаа залгамжлагчийг хэлнэ.
13. “Хөтөлбөр” гэж Хүлээн авагчийн хэрэгжүүлэх энэхүү Хэлэлцээрт тусгасан зорилго, бодлого, арга хэмжээг болон Хэлэлцээрийн



- Хуваарь 1-ийн Хэсэг 1-д заасан, хөтөлбөрийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг эрэлхийлэн Хүлээн авагчаас 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Ассоциацид хүргүүлсэн албан захидалд дурдагдсан арга хэмжээ бүхий хөтөлбөрийг хэлнэ.
14. “Үнэ тогтворжуулах хөтөлбөр” гэж Хүлээн авагчийн Засгийн газар, Монголбанкны хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийг хамтран хэрэгжүүлэх үүднээс байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн дагуу Хүлээн авагчийн хэрэгжүүлж буй хөтөлбөрийг хэлнэ.
  15. “Гарын үсэг зурсан өдөр” гэж энэхүү Хэлэлцээрт Ассоциаци болон Хүлээн авагч талын аль сүүлд гарын үсэг зурсан өдрийг хэлэх бөгөөд энэхүү тодорхойлолт нь Ерөнхий нөхцөлүүдэд тусгагдсан «Санхүүжилтийн хэлэлцээрийн огноо» гэсэн нэр томъёонд мөн хамаарна.
  16. “Нийгмийн халамжийн тухай хууль” гэж 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Хүлээн авагчийн УИХ-аас баталсан нэр бүхий хууль ба түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг хэлнэ.
  17. “Нэг удаагийн татан авалт” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 1-ийн Хэсэг II-ийн Б дэх хүснэгтэд “Нэг удаагийн татан авалт” гэсэн ангилалд хуваарилагдсан санхүүжилтийн хэмжээг хэлнэ.
  18. “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр” гэж худалдааг хөнгөвчлөх зорилгоор Дэлхийн худалдааны байгууллагын бүх гишүүн орнууд (Хүлээн авагчийг оролцуулан) баталсан, 2017 оны 2 дугаар сарын 22-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж буй хэлэлцээрийг хэлнэ.

## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн сайд, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газрыг төлөөлж Холбооны Сангийн сайд нар, цаашид «Гэрээлэгч талууд» гэх:

- Хоёр орны өнөөгийн найрсаг харилцааг цаашид улам өргөжүүлэн хөгжүүлэхийг эрмэлзэж,
- Хамтын ажиллагааг өргөжүүлэн гүнзгийрүүлэхийг эрмэлзэн

Дараахь зүйлийг харилцан тохиролцов. Үүнд:

### **1 дүгээр зүйл**

1.1. Гэрээлэгч талууд нь өөрсдийн орны хууль дүрэм, журам, баримталж буй бодлого болон олон улсад хүлээсэн үүргийн дагуу санхүүгийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжиж, өргөжүүлэхээр чармайн ажиллана.

### **2 дугаар зүйл**

2.1. Бүгд Найрамдах Австри Улсын Холбооны Сангийн сайд Санхүүгийн хамтын ажиллагааг дэмжих, өргөжүүлэх зорилгоор Экспортын санхүүжилтийн системийн дагуу арилжааны банкуудаар дамжуулан Вена хот дахь Австрийн Контролбанк ХК (ОеКВ)-наас дахин санхүүжүүлсэн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэхэд бэлэн байна. Энэхүү 40,000,000 (дөчин сая) еврогийн санхүүжилтийн хүрээнд тус хэлэлцээрт заасан салбарын төслүүдийг санхүүжүүлнэ.

### **3 дугаар зүйл**

3.1. Австрийн хөнгөлөлттэй санхүүжилт нь нөхцөлт тусламжийн зээл хэлбэрээр хөнгөлөлттэй зээлийн хөнгөлөлтийн хамгийн доод түвшиний шаардлагыг хангасан, урьдчилан-холигдсон зээлийн санхүүжилтийн хэлбэрээр олгогдоно.

3.2. Нөхцөлт тусламжийн зээлийн нөхцөл нь Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага (ОУЭЗХАХБ)-ын “Албан ёсны дэмжлэг бүхий экспортын зээлийн журам”, Олон улсын валютын сан (ОУВС)-гийн Өрийн хязгаарын бодлого зэрэг олон улсын баримт бичгийн аль хамааралтайг үндэслэн тогтоогдоно. Нөхцөлт тусламжийн зээлийн хөнгөлөлтийн түвшин нь хамгийн багадаа 35% байна.

Австрийн Зөөлөн зээлийн хөтөлбөрийн нөхцөлийн талаарх нэмэлт мэдээлэл Австрийн Контрол Банк (ОеКВ)-ны цахим хуудас болон <https://www.oekb.at/en/export-services/covering-and-financing-exports/concessional-financing-soft-loan.html> холбоост тавигдсан.

3.3 Гэрээлэгч талууд энэхүү зээлийн хугацаа, нөхцөл нь ОУЭЗХАХБ-ны тохиролцооны дагуу жил бүр шинэчлэн тогтоодог хөнгөлөлтийн түвшин, ОУВС-гийн хөнгөлөлтийн түвшинтэй холбогдон гарч болзошгүй нэмэлт өөрчлөлт, ОУЭЗХАХБ-ын улс, орнуудын эрсдэлийн ангилал зэргээс хамаарч өөрчлөгдөж болохыг тэмдэглэж байна.

### **4 дүгээр зүйл**

4.1. Энэхүү хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг Гэрээлэгч талууд гаргах ба шаардлагатай тохиолдолд Гэрээлэгч талууд шинэчлэн тогтооно.

4.2. Энэхүү хэлэлцээрийн хүрээнд санхүүжүүлэх эрх бүхий төслүүдийг “Хэлсинки”-гийн нөхцөлт тусламжийн журам болон улсын



төсвийн хуваарилалтын шалгуур үзүүлэлтийн аль тохиромжтойг харгалзан үнэлэн, тогтооно.

4.3. “Хэлсинки”-гийн нөхцөлт тусламжийн журмын дагуу санхүүжүүлэх боломжгүй төслүүдийн туршлагыг үндэслэн хөнгөлөлттэй санхүүжилтийн дараах салбар/төсөл-т тэнцвэртэй тархалтыг харгалзан олгоно. Үүнд:

- Дэд бүтэц;
- Хотын усан хангамж, ариун цэвэр;
- Бохир ус, хог хаягдал;
- Төмөр замын болон замын хөдөлгөөний аюулгүй байдал;
- Боловсрол, мэргэжлийн боловсролын сургалт;
- Эрүүл мэнд, иргэний хамгаалал (хот, орон нутгийн гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаа, гамшгийн анхааруулга гэх мэт);
- Хөдөө аж ахуй;
- Бусад нийгмийн дэд бүтэц.

#### **5 дугаар зүйл**

5.1. Төслийн худалдан авах ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу явуулна.

#### **6 дугаар зүйл**

6.1. Австрийн Контрол банк (OeKB)-наас дахин санхүүжигдэх зээлийн гэрээний нөхцөлийг зээлдүүлэгч болох арилжааны банкууд болон зээлдэгч болох Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн яамны хооронд тохирч шууд хэлэлцээ хийх замаар байгуулна.

#### **7 дугаар зүйл**

7.1. Энэхүү хэлэлцээрт хамрагдан санхүүжигдэх төслүүдийг Монгол Улсын Сангийн яам, Бүгд Найрамдах Австри Улсын Холбооны Сангийн яам хооронд солилцох захидлаар харилцан тохиролцоно.

Хэлэлцээрийн дагуу албан үйл ажиллагаа нь дэс дараалсан байдлаар явагдана. Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө хэлэлцэж байсан төслүүдийг мөн хамруулж болно.

#### **8 дугаар зүйл**

8.1. Хэлэлцээрийн хүрээнд олгож буй нөхцөлт тусламжийн зээлийн хөрөнгийг Австри Улсын гарал үүсэл бүхий бараа, үйлчилгээг худалдан авахад ашиглах бөгөөд хөрөнгийн 50 хүртэлх хувийг Бүгд Найрамдах Австри Улсын бус гарал үүсэлтэй бараа, бүтээгдэхүүний худалдан авалтад ашиглаж болно.

### **9 дүгээр зүйл**

9.1. Энэхүү хэлэлцээрийн хүрээнд бий болж буй бүх төлбөрийг эргэж буцалтгүйгээр, үл маргах замаар гүйцэлдүүлэхийг Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн яам үүгээр баталгаажуулан, энэхүү хэлэлцээрээр баталгаажуулсан төлбөрөөс чөлөөлөгдөх аливаа эрхээсээ эргэж буцалтгүйгээр түдгэлзэв.

### **10 дугаар зүйл**

10.1. Австрийн экспортын санхүүжилтийн системийн дэмжлэгтэйгээр олгогдсон албан ёсны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр худалдан авсан бараа, үйлчилгээ нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ногдуулах нэмэгдсэн өртгийн албан татвар болон гаалийн татвараас чөлөөлөгдөнө.

10.2 Австрийн экспортын санхүүгийн системийн дэмжлэгтэйгээр олгогдсон албан ёсны хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хийгдсэн төлбөрт үзүүлж буй татварын чөлөөлөлтийг 2003 оны 7 дугаар сарын 3-ны өдөр байгуулсан “Орлого ба хөрөнгийн татварын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Австри Улс хоорондын конвенц”-ийн дагуу зохицуулна.

### **11 дүгээр зүйл**

11.1 Гэрээлэгч талууд энэхүү хэлэлцээрийн явцыг үнэлж, шинэчлэлтийн асуудлыг хэлэлцэн гарч болзошгүй бусад асуудлаар жил бүр эсхүл шаардлагатай тохиолдолд тухай бүр харилцан тохиролцоно.

### **12 дугаар зүйл**

12.1 Хөнгөлөлттэй зээлийн ашиглалтыг үнэлэх зорилгоор энэхүү хэлэлцээрийн хүрээнд болон холбогдох төслүүдийн тогтвортой байдлыг хангах үүднээс Монгол Улсын Засгийн газар төслүүдийн хэрэгжилтийн явцыг үнэлэх, хянах, аудит хийхэд шаардлагатай бүхий л баримт бичгээр хангахад дэмжлэг үзүүлнэ.

### **13 дугаар зүйл**

13.1 Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх ба/эсхүл тайлбарлахад Гэрээлэгч талуудын хооронд үүссэн аливаа маргааныг найрсгаар дипломат шугамаар шийдвэрлэнэ.

### **14 дүгээр зүйл**

14.1 Хэлэлцээр нь Гэрээлэгч талууд дотоодынхоо хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа харилцан мэдэгдсэн сарын дараагийн сарын эхний өдрөөс хүчин төгөлдөр болно.





14.2 Энэхүү хэлэлцээрийн хүчин төгөлдөр хугацаа хоёр (2) жил байна. Гэрээлэгч талуудын нэг нь аль ч үед гэрээг дуусгавар болгоогүй бол харилцан зөвшөөрсний үндсэн дээр цааш хоёр жилийн хугацаагаар гэрээний хугацааг шинэчилж болно.

14.3 Хэлэлцээрийг дуусгавар болгохын тулд 6 сарын өмнө бичгээр мэдэгдэнэ.

Хэлэлцээрийг цуцлах нь энэхүү хэлэлцээрийн дагуу хэрэгжиж буй үйл ажиллагаатай холбоотой Гэрээлэгч талуудын үүрэгт нөлөөлөхгүй.

Хэлэлцээрийг 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Вена хотноо, 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Улаанбаатар хотноо монгол, герман, англи хэлээр 2 эх хувь байгуулсан бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Монгол, герман хэлээрх эх бичвэрийг тайлбарлахад зөрүү гарсан тохиолдолд англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ САНГИЙН  
САЙД**

**БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ  
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ ХОЛБООНЫ САНГИЙН  
САЙД**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turin\_medecelel@parliament.mn

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 5,5

**Индекс:** 200003